



Монгол Улсын Авлигатай тэмцэх газар

**МОНГОЛ УЛСЫН АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ХЭРЭГЖИЛТ,
АВЛИГЫН ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ БАЙДЛЫН ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ**

Агуулга

Агуулга.....	2
НЭГДҮГЭЭР ХЭСЭГ: МОНГОЛ УЛСЫН АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ.....	4
I.1 Авлигын эсрэг олон нийтийг соён гэгээрүүлэх, авлигаас урьдчилан сэргийлэх чиглэлээр:.....	5
I.2 Хөрөнгө, орлогын мэдүүлгийг бүртгэх, хадгалах, хянан шалгах чиглэлээр:.....	9
I.3 Иргэд, байгууллагаас ирсэн гомдол, мэдээллийг хянан шалгах чиглэлээр:.....	15
I.4 Хуулиар харьяалуулсан гэмт хэрэгт явуулсан мөрдөн байцаалтын чиглэлээр:.....	16
I.5 Гадаад харилцааны чиглэлээр:.....	21
ХОЁРДУГААР ХЭСЭГ: МОНГОЛ УЛСЫН АВЛИГЫН ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ БАЙДЛЫН ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ.....	23
.....	23
II.1 Монгол Улс дахь авлигын ерөнхий нөхцөл байдал.....	24

Хүснэгтийн жагсаалт

Хүснэгт 1. Албан тушаалтнуудын мэдүүлгийн бүрдүүлэлт сүүлийн 3 жилийн байдлаар.....	12
Хүснэгт 2. Хяналт шалгалтаар хариуцлага тооцуулсан албан тушаалтан 2011, 2012 оны байдлаар....	14
Хүснэгт 3. Авлигын төсөөллийн индексийн утга болон үнэлгээнд хамрагдсан улс орнууд дунд эзлэх байр.....	24
Хүснэгт 4. Бизнесийн үйл ажиллагаан дахь гол бэрхшээлүүд, дунд эзлэх хувиар.....	27
Хүснэгт 5. Төрийн байгууллагын шударга байдлын түвшний үнэлгээ.....	29
Хүснэгт 6. Улс төрийн хүрээн дэх авлигыг нөхцөлдүүлэгч хүчин зүйлсийн үнэлгээ.....	33
Хүснэгт 7. Шүүх, хуулийн байгууллагын хүрээн дэх авлига үүсэхэд нөлөөлж буй хүчин зүйлсийн нөлөөллийн үнэлгээ.....	34

Зургийн жагсаалт

Зураг 1. Албан тушаалтнуудын хариуцлага тооцуулсан байдлын тоо, сүүлийн 3 жилийн байдлаар....	13
Зураг 2. Өргөдөл гомдлын агуулгын зөрчлийн хэлбэр.....	16
Зураг 3. Мөрдөн байцаалт явуулсан гэмт хэрэг /төрлөөр/.....	17
Зураг 4. Сэжигтэн, яллагдагч /албан тушаалын ангиллаар/.....	18
Зураг 5. Авлигыг бүүруулах арга зам.....	26
Зураг 6. Бизнесийн үйл ажиллагаанд хамгийн их саад учруулж байгаа байгууллагууд.....	27

Зураг 7. Танай байгууллагын удирдлага үйлдвэрлэлийн бус асуудлуудыг шийдвэрлэхэд ажлын цагийн хэдэн хувийг зарцуулдаг вэ? хувь, компанийн хэмжээгээр.....	28
Зураг 8. Та одоогийн ЗГ-аас явуулж байгаа явлигын эсрэг үйл ажиллагааны талаар хэр сайн мэдэх вэ?	28
Зураг 9. Улс төр, хууль хяналтын байгууллагын хүрээн дэх авлигын талаарх шинжээчдийн төсөөллийн үзүүлэлт.....	32
Зураг 10. Улс төр, хууль хяналтын байгууллагын хүрээн дэх авлигын талаарх шинжээчдийн төсөөллийн үзүүлэлт.....	33

**НЭГДҮГЭЭР ХЭСЭГ: МОНГОЛ УЛСЫН АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ХУУЛЬ
ТОГТООМЖИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ**

Авлигатай тэмцэх газар нь Монгол Улсад шударга ёсыг бэхжүүлэх, төрийн байгууллагын үйл ажиллагааны нээлттэй, ил тод байдлыг хангах, хүнд суртал, чирэгдлийг арилгах, авлигын гэмт хэргийг илрүүлэх, хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт явуулах, хөрөнгө, орлогын мэдүүлгийг бүртгэх, хадгалах, хянан шалгах талаар цогц арга хэмжээг хэрэгжүүлэн, авлигаас урьдчилан сэргийлэх, авлигын эсрэг олон нийтийг соён гэгээрүүлэх ажлыг төрийн болон төрийн бус байгууллага, хувийн хэвшил, хэвлэл мэдээллийн байгууллага, иргэдийн өргөн оролцоотойгоор улсын хэмжээнд зохион байгуулав.

Монгол Улсын Их Хуралд Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, Эрүүгийн болон Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн зарим зүйл, заалт, УИХ-ын 2007 оны 07, 2008 оны 13, 2011 оны 55, 2012 оны 55 дугаар тогтоол, УИХ-ын Хууль зүйн байнгын хорооны 5 дугаар тогтоолын хэрэгжилт болон авлигын ерөнхий нөхцөл байдлыг мэдээлж байна.

I.1 Авлигын эсрэг олон нийтийг соён гэгээрүүлэх, авлигаас урьдчилан сэргийлэх чиглэлээр:

Монгол Улсын Их Хурлаар 2012 оны 1 дүгээр сарын 19-ний өдөр баталсан Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн хэрэгжилтийг ханган ажиллав. Уг хуульд заасны дагуу “Албан тушаалтны төрийн өмчлөлд шилжүүлсэн бэлэг, үйлчилгээг үнэлэх, хадгалах, зарцуулах журам” болон “Албан тушаалтан дипломат журмаар бэлэг хүлээн авах, тайлагнах, зарцуулах журам”-ыг тус тус боловсруулан Засгийн газрын 2012 оны 133, 141 дүгээр тогтоолоор батлууллаа.

Мөн “Албан тушаалтан өөрт ногдуулсан сахилгын шийтгэлийн талаарх мэдээллийг холбогдох этгээд болон нийтэд өөрийн зардлаар хүргэх арга хэмжээний журам”-ыг Авлигатай тэмцэх газрын даргын тушаалаар батлуулж, журмуудыг нийтийн албан тушаалтанд сурталчлан таниулах ажлыг зохион байгуулсан.

Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийг үр дүнтэй хэрэгжүүлэхэд бусад улс орны сайн туршлагыг судлах зорилгоор Дэлхийн банкны холбогдох мэргэжилтнүүдтэй хамтран дүрст хурлуудыг зохион байгуулж, тухайн улс орнуудын сайн туршлага болсон арга хэмжээг өөрийн улсын онцлогт уялдуулах үүднээс тодорхой санал боловсруулан ажиллалаа.

Авлигаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтийг үнэлэн, төрийн үйлчилгээний ил тод, нээлттэй байдлыг хангах талаар зөвлөмж хүргүүлэв. Авлигатай тэмцэх газраас яам, агентлаг, аймаг,

нийслэлийн төрийн байгууллагуудад Авлигаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтийн дүнг үнэлэх, тайлагнах талаар хүргүүлсэн Зөвлөмжийн дагуу төлөвлөгөөний хэрэгжилтэд өөрийн үнэлгээ хийсэн 11 яам, 43 агентлаг, 21 аймаг, нийт 76 байгууллагын 2011 оны төлөвлөгөөний хэрэгжилтийн тайланг хүлээн авч судлан, дүн шинжилгээ хийж, төрийн яам, агентлаг, нийслэл, аймаг орон нутгийн байгууллагуудаас гадна УИХ-ын дэргэдэх байгууллагууд, хууль сахиулах байгууллагууд, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдтэй авлигаас урьдчилан сэргийлэх чиглэлээр хамтран ажиллах эхлэлийг тавьсан нь үр дүнтэй ажил боллоо.

Төрийн захиргааны болон нутгийн захиргааны байгууллагаас үзүүлж буй төрийн үйлчилгээний ил тод, нээлттэй байдал, албан хаагчдын ёс зүй, зан харьцааны байдалд тандалт хийж, тухайн байгууллагад гарсан амжилт ололт, зөрчил дутагдалтай холбоотой үр дүнг хэлэлцэх, зөвлөмж өгөх зорилгоор нийт 44 байгууллагад ажилласан ба тандалт хийх явцад зарим байгууллагын мэдээллийн самбар дахь мэдээлэл хуучирсан, ажилтнууд цагтаа ирдэггүй, үйлчилгээ үзүүлж буй ажилтнууд иргэдтэй зүй бусаар харьцдаг, иргэдтэй уулзах цагийн хуваарь тодорхойгүй, зарим байгууллага мэдээллийн самбаргүй, ажлын ачаалал их, байрны хүрэлцээ муу, дотоод ажил, сургалттай байдаг, иргэдэд үйлчлэх дугаар олгох төхөөрөмжийг зогсоосон зэрэг нийтлэг дутагдлууд илэрсэн болно. Энэхүү нөхцөл байдалд үндэслэн Авлигатай тэмцэх газрын даргын албан захидлыг байгууллагын удирдлагад гардуулах, авлигаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг дүгнэх хуудсыг танилцуулах зэрэг арга хэмжээг авч хэрэгжүүлсэний зэрэгцээ төрийн байгууллагын албан ёсны цахим хуудсан дахь ил тод байдлыг хэрхэн хангаж байгаад үнэлэлт дүгнэлт хийх аргачлал боловсруулан мөрдөж байна.

“Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр”-ийн хэрэгжилтэд дүн шинжилгээ хийв. Улсын Их Хурлын 2002 оны 41 дүгээр тогтоолоор батлагдсан “Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр”-ийн хэрэгжих хугацаа 2010 онд дууссантай холбогдуулан түүний биелэлтийн үр дүнг тооцох, авлигатай тэмцэх, авлигаас урьдчилан сэргийлэх чиглэлээр дэвшүүлсэн зорилтын хэрэгжилтэд үнэлэлт дүгнэлт өгөх, хөтөлбөрт дурдсан арга хэмжээний үр нөлөөг судлах зорилгоор Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга, Авлигатай тэмцэх газрын даргын хамтарсан тушаалын дагуу хөтөлбөрийн хэрэгжилтэд дүн шинжилгээ хийсэн нэгдсэн тайлан гаргав.

НҮБ-аас тунхагласан Авлигын эсрэг олон улсын өдрийг угтсан 1 сарын аянг өрнүүлэн Монгол Улсын Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, Хууль зүйн яам, Монголын залуучуудын холбоо, Мерси кор олон улсын байгууллага, АНУ-ын Азийн сантай хамтарсан ажлын хэсэг байгуулан ажиллав. Энэ ажлын хүрээнд Их, дээд сургуулийн оюутнуудын дунд нийгмийн шударга ёсыг түгээн дэлгэрүүлэх, хувь хүний зөв ёс суртахууныг дээдлэх, шударга зан үйлийг төлөвшүүлэх, бусдад уриалах зорилго бүхий “Миний мэдэх шударга ёс” сэдэвт

шилдэг зохион бичлэгийн уралдааныг зарлаж, хэвлэл мэдээллийн хэрэгслээр олон нийтэд түгээх, уралдаанд ирүүлсэн бүтээлүүдийг бүртгэх, шалгаруулах, шагнал гардуулах арга хэмжээг зохион байгуулсан. Уралдаанд шалгарсан 8 бүтээлийг мэдээллийн цахим хуудсаар дамжуулан олон нийтэд сурталчилснаас гадна Сайн засаглалыг бэхжүүлэх, авлига, хүнд суртлаас ангид байхын төлөө амжилттай ажиллаж буй сайн туршлагыг шалгаруулах зорилгоор “Төрийн үйлчилгээний сайн туршлага” цуврал мэдээлэл бэлтгэж, байгууллагын цахим хуудас болон мэдээллийн бусад сайтуудаар дамжуулан олон нийтийн хүртээл болгох, түгээн дэлгэрүүлэх ажлыг зохион байгууллаа.

“Төрийн үйлчилгээний сайн туршлага”-ыг шалгаруулан олон нийтэд түгээн дэлгэрүүлэх арга хэмжээг зохион байгуулав. “Мерси Кор” олон улсын байгууллагатай хамтран Сайн засаглалын туршлагыг бий болгон, авлига, хүнд суртлаас ангид байхын төлөө идэвх санаачилгатай ажилласан төрийн байгууллага, албан хаагчийн үйл ажиллагааг тодруулан шалгаруулж, олон нийтэд мэдээлэх, шагнал гардуулах арга хэмжээг Монголын Үндэсний олон нийтийн телевизээр шууд нэвтрүүлэв.

“Авлигаас ангид байх амлалтын дэвтэр”-ийг аялуулав. Монголын Залуучуудын холбоотой хамтран “Авлигын эсрэг төр болон иргэний байгууллагын түншлэл” нээлттэй хэлэлцүүлэг өрнүүлэн, “Авлигаас ангид байх амлалтын дэвтэр”-ийг төрийн байгууллага, яам, агентлагаар аялуулах ажлыг зохион байгуулж 15 байгууллагыг хамруулан хэвлэл, мэдээллийн хэрэгсэл, радио телевизээр сурталчлах ажлыг зохион байгуулав.

Багш нарыг авлигын эсрэг хичээлийг заах арга барилд сургах ажлыг эхлүүлэв. АНУ-ын Азийн сангийн дэмжлэгтэйгээр нийслэлийн Боловсролын газартай хамтран 20 сургуулийн түүх, нийгмийн ухааны 60 багшид “Авлигын эсрэг боловсрол” олгох арга хэмжээг амжилттай зохион байгууллаа. Энэ хүрээнд “Авлигын эсрэг боловсрол” гарын авлагыг улам боловсронгуй болгох, багш нарт зориулсан сургалтыг зохион байгуулах, сургууль тус бүрт туршилт хичээл явуулахад туслалцаа үзүүлэх, хичээлийг зохион байгуулсан багш нарт арга зүйн зөвлөгөө өгөх ажлыг хийж гүйцэтгэлээ. Энэхүү арга хэмжээг зохион байгуулснаар ерөнхий боловсролын сургуулийн дунд, ахлах ангийн сургалтын агуулга, хөтөлбөрт шударга ёсны сэдвээр тусгайлсан хичээл тусгах, энэ чиглэлийн бэлтгэл ажлыг хангах, уг хичээлийг заах багш нарт авлигын эсрэг мэдлэг, ойлголт бий болгох, тэдний заах арга барилыг дээшлүүлэх зэрэг ач холбогдолтой байв.

Авлигын эсрэг олон нийтийг соён гэгээрүүлэх, авлигатай тэмцэх талаар явуулж буй үйл ажиллагааг олон нийтэд хүргэх ажлыг төрөл бүрийн арга хэлбэрээр явуулан, төрийн албан хаагч, иргэдэд сургалт зохион байгуулав. Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг

сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийг нийт төрийн албан хаагчдад таниулан сурталчлах арга хэмжээний хүрээнд “Авлигын эсрэг эрх зүйн баримт бичгийн эмхтгэл”-ийг төрийн байгууллагуудад хүргүүлэн, “Ашиг сонирхлын зөрчлийн хууль ба 100 асуулт, хариулт” ном, албан тушаалтанд тавигдах 12 төрлийн хориглолт, хязгаарлалт тус бүрийг танилцуулсан “Нийтийн албан тушаалтан Танд үүнийг хориглоно” хэмээх гарын авлагыг боловсруулан тус бүр 25000 ширхэгийг хэвлүүлэн нийтийн албан тушаалтнуудад түгээсэн. Мөн “Нийтийн албан тушаалтны 5 зарчим”, “Хуулийн тухай танилцуулга” сэдвээр нугалбар /брошюр/-ууыг олон нийтийн хүртээл болголоо. Хөрөнгө, орлогын мэдүүлэг гаргагч, эрх бүхий албан тушаалтнуудад зориулсан гарын авлага, зөвлөмжийг шинэчлэн хэвлүүлж, төрийн болон орон нутгийн захиргааны байгууллагуудад гарын авлага 2500 ш, хөрөнгө, орлогын мэдүүлгийг бүртгэх, хадгалах эрх бүхий албан тушаалтанд зориулсан зөвлөмж 1500 ш, ХОМ гаргагчид зориулсан хэвлэмэл хуудас 15000 ширхэгийг тус тус хуваарилан хүргүүлэв.

2012 онд авлигаас урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх арга хэмжээг хэрэгжүүлэх чиглэлээр аж ахуйн нэгж, байгууллагын хүлээх үүрэг, авлигын нийгмийн хор аюул, төрийн байгууллагын ажилтны ёс зүйн асуудлаар лекц, ярианы сэдэв боловсруулах, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбогдуулан уг хуулийг сурталчлах, ухуулан таниулах ажлыг улсын хэмжээнд зохион байгуулж, иргэн болон төрийн албан хаагчдад зориулсан сургалтыг тус тус тогтмол зохион байгуулсан. Тухайлбал, “Авлигын талаарх ойлголт, авлигын шалтгаан нөхцөл, хор уршиг”, “Авлигын эсрэг хууль тогтоомж”, “Авлигаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны төлөвлөлт, “Төрийн албаны ёс зүй”, “Ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх нь”, “Байгууллагын түвшинд авлигаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа”, “Төрийн байгууллагын ил тод байдал”, “Орон нутагт Авлигын эсрэг хуулийг хэрэгжүүлэхэд анхаарах асуудал” “Үндэсний шударга ёсны тогтолцоо”, “Сонирхлын зөрчлийг удирдах нь”, “Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх нь” зэрэг сэдвүүдээр 79 байгууллага, тэдгээрийн харьяа нэгжийн нийт **18095** төрийн албан хаагчид сургалт явуулав.

2012 онд сургалтад хамрагдагсан албан хаагчдын тоог 2010 онтой харьцуулбал 9211-ээр илүү буюу 2,0 дахин, 2011 онтой харьцуулбал 6297-оор илүү буюу 1,5 дахин өссөн байна.

Түүнээс гадна зөвхөн Хувийн ашиг сонирхлын болон хөрөнгө орлогын мэдүүлэг гаргах талаар **416** байгууллагын **20435** албан тушаалтанд мэдүүлгийг хэрхэн бөглөх болон хууль тогтоомжийн талаар сургалт хийснээс **18991** нь мэдүүлэг гаргагч, **1444** нь мэдүүлгийг бүртгэх, хадгалах эрх бүхий албан тушаалтан байна.

Авлигатай тэмцэх газрын /<http://www.iaac.mn/> цахим хуудсын агуулгыг сайжруулж, шинэчлэх ажлыг зохион байгуулсан бөгөөд цахим хуудсаар авлигын эсрэг, шударга ёсны үзэл санааг дэлгэрүүлэх чиглэлийн мэдээллийг тогтмол хүргэж ажиллав. Байгууллагын цахим хуудсаар 2012 он дуусталх хугацаанд давхардсан

тоогоор **266800**, сард дунджаар давхардсан тоогоор **4105** иргэн зочлон, мэдээлэл авч, санал сэтгэгдэл, өргөдөл гомдол, хүсэлтээ илгээсэн байна. Байгууллагын цахим мэдээллийн хуудсанд хандсан зочдын тоог 2011 онтой харьцуулбал 2012 онд 3 хувиар өсчээ. Авлигатай тэмцэх газрын үйл ажиллагааг сурталчлах, авлигын эсрэг олон нийтийг соён гэгээрүүлэх зорилгоор нийгмийн сүлжээний веб хуудас болох <http://www.facebook.com/pages/авлигатай-тэмцэх-газар-independent-authority-against-corruption-of-mgl>, <https://twitter.com/nocorruptionmgl> - зэрэг хуудсуудыг нээж хөтлөн явуулах эхлэлийг тавилаа.

Авлигатай тэмцэх газрын үйл ажиллагааг танилцуулах, шинээр батлан гаргасан хууль тогтоомжийг сурталчлах зорилгоор “Авлигын эсрэг хамтдаа” арга хэмжээг улирал тутам зохион байгуулж хэвшлээ.

2012 онд явуулсан авлигаас урьдчилан сэргийлэх, олон нийтийг соён гэгээрүүлэх, мөрдөн шалгах болон хөрөнгө, орлогын мэдүүлгийн хяналт шалгалтын үйл ажиллагаатай холбоотой мэдээ, мэдээлийг бэлтгэн олон нийтэд тухай бүр шуурхай түгээн, байгууллагаас авч хэрэгжүүлж байгаа үйл ажиллагааны талаарх мэдээллийг олон нийтэд хамгийн хүртээмжтэй хэлбэрээр хүргэдэг “Шинэ хуудас” мэдээллийн хуудсыг шуудангийн хайрцагар айл өрхүүдэд хүргэсэн.

Монгол Улсын Авлигын нөхцөл байдлыг судалж олон нийтэд мэдээлэх ажлыг зохион байгуулав. “Авлигын индекс-2011” судалгааны үр дүнг олон нийтэд түгээсний зэрэгцээ “Монгол Улсын авлигын индексийн тооцооны үр дүнгийн тайлан”-г дэлгэрэнгүй болон хураангуй байдлаар бэлтгэн хүргүүлсэн нь олон нийтийг авлигын нөхцөл байдлын тухай бодит мэдээллээр хангахад чиглэсэн ач холбогдолтой арга хэмжээ болов. УИХ-ын 2008 оны 13 дугаар тогтоолын дагуу Улс төр, хууль хяналтын байгууллагын хүрээн дэх авлигын талаарх шинжээчийн төсөөллийн судалгаа болон төрийн үйлчилгээний 10 салбарын байгууллагуудаар үйлчлүүлсэн иргэд, байгууллагын дунд зохион байгуулсан судалгааны үр дүнд үндэслэн Төрийн байгууллагын шударга байдлын түвшний үнэлгээг гаргаж үр дүнгийн тайланг төрийн байгууллага, албан тушаалтнуудад тараан, мэдээлэл зөвлөгөөг өгч ажиллав.

I.2 Хөрөнгө, орлогын мэдүүлгийг бүртгэх, хадгалах, хянан шалгах чиглэлээр:

Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, тэдгээртэй нийцүүлэн гаргасан журмын дагуу 2012 оны мэдүүлгийн бүрдүүлэлтийн үйл ажиллагааг улсын хэмжээнд 2 удаа зохион байгуулав. Төрийн албан хаагчийн хөрөнгө, орлогын мэдүүлгийн бүрдүүлэлтийг улсын хэмжээнд зохион байгуулахдаа хөрөнгө, орлогын мэдүүлгийг бүртгэж, хадгалдаг байгууллага, мэдүүлэг гаргах албан тушаалтны нэрсийн жагсаалтад тогтмол баяжилт хийж, хөрөнгө, орлогын мэдүүлгийг бүртгэж, хадгалах эрх бүхий /шинээр томилогдсон/ албан

тушаалтнуудад заавар, зөвлөмж өгөх, гарын авлагаар хангах зэргээр мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлж тасралтгүй хамтран ажиллаж байна.

Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, Авлигын эсрэг хуулийн үйлчлэлд хамаарах байгууллага, албан тушаалтны нэрсийн жагсаалт, Авлигатай тэмцэх газарт мэдүүлгээ бүртгүүлэх албан тушаалтны нэрсийн жагсаалтыг тус тус гарган, Хувийн ашиг сонирхлын мэдүүлгийн болон хөрөнгө орлогын мэдүүлгийг бүртгэх тайлан, мэдээ, бүртгэлийн 6 төрлийн маягтыг хөтлөх зааврыг боловсруулж батлуулан хэрэгжүүлж байна. Албан тушаалтны хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлгийн талаар мэдээлэх, мэдээлэл өгөх журам, мэдүүлгийг бүртгэх, хадгалах эрх бүхий албан тушаалтны үйл ажиллагааны журмыг газрын даргын тушаалаар батлуулан тэдгээрийг төрийн болон нутгийн захиргааны 112 байгууллага, УИХ-ын Хууль зүйн байнгын хороонд хүргүүлж газрын цахим хуудсанд байршуулав.

Төрийн албан хаагчид хөрөнгө, орлогын мэдүүлгээ хугацаанд нь мэдүүлж хэвшлээ. Авлигатай тэмцэх газарт нийт 270 албан тушаалтан хөрөнгө, орлогын мэдүүлэг (**ХОМ**)-ээ бүртгүүлсэн байна. Тус газарт мэдүүлгээ бүртгүүлдэг албан тушаалтнуудын хөрөнгө, орлогын мэдүүлгийг хуульд заасан хугацаанд 100 хувь хүлээн авч бүртгэсэн. Төрийн өндөр албан тушаалтнуудын 2011 оны хөрөнгө, орлогын мэдүүлгийг “Төрийн мэдээлэл” эмхэтгэлд нийтлүүлсэн ба газрын цахим хуудсанд байршуулж олон нийтэд нээлттэй болгов.

Улсын хэмжээнд 2012 оны 02 дугаар сарын 15-ны өдрийн хөрөнгө, орлогын мэдүүлгийн бүрдүүлэлтээр нийт **58000 орчим** албан тушаалтан хөрөнгө, орлогын мэдүүлгээ бүртгүүлэхээс 99,89 хувь нь хөрөнгө, орлогын мэдүүлгээ бүртгүүлжээ. Нийт мэдүүлэг гаргагчдын 99,84 хувь нь мэдүүлгээ хуульд заасан хугацаанд, **25** албан тушаалтан хугацаа хожимдуулж бүртгүүлсэн, 64 албан тушаалтан огт бүртгүүлээгүй байна. Хөрөнгө, орлогын мэдүүлгээ бүртгүүлээгүй **64** мэдүүлэг гаргагчийн **50** нь буюу 78,1 хувь нь аймаг, сумдын Иргэдийн Хурлын Төлөөлөгчид байна.

Нийтийн албан тушаалтнууд Хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлэг (ХАСХОМ)-ээ анх удаа бүртгүүлэв. Хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлгийн бүрдүүлэлтээр тус газарт мэдүүлгээ бүртгүүлбэл зохих 253 албан тушаалтнаас 252 нь буюу 99.6 хувь нь мэдүүлгээ хуулийн хугацаанд бүртгүүлсэн байна.

Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, Авлигын эсрэг хуулийн үйлчлэлд хамаарах албан тушаалтнуудын хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлгийг шинэчлэн бүртгэх ажлыг улсын хэмжээнд зохион

байгуулж, төрийн болон нутгийн захиргааны 121 төв байгууллагаас мэдүүлгийн тайлан болон Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хороо, Шүүхийн ерөнхий зөвлөлийн Шүүхийн Сахилгын Хороонд бүртгэж, хүлээн авсан мэдүүлгийн тоог нэгтгэхэд улсын хэмжээнд 2012 оны 8 дугаар сарын 15-ны байдлаар **45000 орчим** албан тушаалтан хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлэг гаргахаас **99,79** хувь нь мэдүүлгээ бүртгүүлсэн ба 7 албан тушаалтан хугацаа хожимдуулж бүртгүүлсэн, **96** албан тушаалтан мэдүүлгээ гаргаж өгөөгүй байна.

Төрийн болон нутгийн захиргааны төв байгууллагын нийт мэдүүлэг гаргагчдын дүн мэдээ, тайланг хуулийн хугацаанд бүрэн нэгтгэж гаргасны зэрэгцээ албан тушаалтны 2012 оны хөрөнгө, орлогын мэдүүлгийн бүрдүүлэлт, хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлгийн шинэчилсэн бүрдүүлэлтийн нэгдсэн дүнгийн тухай танилцуулах тойм мэдээг бэлтгэж, Үндэсний аюулгүй байдлын Зөвлөл болон УИХ-ын Хууль зүйн байнгын хороонд тус тус хүргүүлэв.

Мэдүүлгийн эхний бүрдүүлэлтээр хөрөнгө, орлогын мэдүүлгээ бүртгүүлээгүй 64, хугацаа хожимдуулж мэдүүлсэн 25 албан тушаалтанд Авлигын эсрэг хуулийн холбогдох заалтыг үндэслэн хариуцлага тооцуулах албан бичгийг төрийн болон нутгийн захиргааны 39 байгууллагын удирдах албан тушаалтанд хүргүүлсэн. Нийт 89 албан тушаалтанд хариуцлага тооцуулахаас хүндэтгэн үзэх шалтгаантай /хүнд өвчний улмаас удаан хугацаанд чөлөөтэй байгаа/ 3, төрийн өмчийн 20-49 хувийн оролцоотой хуулийн этгээдийн удирдах ажилтан 4, ажлаас чөлөөлөгдсөн, шилжсэн 14 албан тушаалтан, нийт 21 албан тушаалтанд хариуцлага тооцох боломжгүй гэсэн хариу ирүүлсэн байна. Хариуцлага тооцох 68 албан тушаалтнаас 66 албан тушаалтанд буюу 1 албан тушаалтанд халах, 1 албан тушаалтанд цалинг 3 сарын хугацаанд 20 хувиар бууруулах, 53 албан тушаалтанд сануулах сахилгын шийтгэл, 7 албан тушаалтанд анхааруулах, 4 албан тушаалтанд бүрэн эрхийг нь түтгэлзүүлэх арга хэмжээг авсан байна.


Мэдүүлгийн шинэчилсэн бүрдүүлэлтээр мэдүүлгээ гаргаж өгөөгүй болон хугацаа хожимдуулж бүртгүүлсэн албан тушаалтнуудад хариуцлага тооцуулахаар 27 байгууллагын удирдах албан тушаалтанд албан бичиг хүргүүлэх ажлыг зохион байгуулсан ба 22 байгууллагаас ажлаас халсан-4, цалинг бууруулсан-1, сануулсан-26, анхааруулсан-18, хариуцлага тооцох боломжгүй-12 албан тушаалтан, нийт 61 албан тушаалтанд хариуцлага тооцсон талаар хариу ирүүлсэн байна. Албан тушаалтнуудын мэдүүлгийн бүрдүүлэлтийг сүүлийн 3 жилийн байдлаар харьцуулав (Хүснэгт 1).

Хүснэгт 1. Албан тушаалтнуудын мэдүүлгийн бүрдүүлэлт сүүлийн 3 жилийн байдлаар

Үзүүлэлт		2010 он	2011 он	2012 он	2012 оны шинэчилсэн бүрдүүлэлтээр
ХОМ-ээ бүртгүүлбэл зохих мэдүүлэг гаргагчийн тоо		54604	56832	58251	45858
ХОМ-ээ бүртгүүлсэн мэдүүлэг гаргагчийн тоо		54468	56763	58187	45762
Хуулийн хугацаанд бүртгүүлсэн		54453	56714	58162	45755
Хугацаа хожимдуулж бүртгүүлсэн		15	49	25	7
Огт бүртгүүлээгүй мэдүүлэг гаргагчийн тоо		136	69	64	96
Үүнээс	Иргэдийн төлөөлөгчдийн хурлын төлөөлөгч	98	61	50	80
	Бүртгүүлээгүй бусад мэдүүлэг гаргагч	38	8	14	16
Бүрдүүлэлтийн хувь		99,75	99,87	99,89	99,79
ХОМ-ийн зөрчлөөр хариуцлага тооцуулсан албан тушаалтны тоо, бүгд		58	73	66	49
Үүнээс : -сануулах арга хэмжээ		24	55	53	26
-анхааруулах арга хэмжээ		-	-	11	18
-цалинг бууруулсан		30	15	1	1
-зэрэг дэвийг бууруулсан		-	2	-	
-ажлаас халсан		4	1	1	4

Албан тушаалтнуудын хариуцлага тооцуулсан байдлыг сүүлийн 3 жилийн байдлаар (Зураг 1) харьцуулав.

Зураг 1. Албан тушаалтнуудын хариуцлага тооцуулсан байдлын тоо, сүүлийн 3 жилийн байдлаар



2012 онд Авлигатай тэмцэх газрын 73 албан тушаалтны хөрөнгө, орлогын мэдүүлгийг хуулийн хугацаанд хүлээн авч, тайлан, мэдээ, нэрсийн жагсаалтыг хуулийн хугацаанд гаргаж нэгтгэв. Түүнчлэн 90 албан тушаалтны хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлэг, мөн шинээр томилогдсон, их хэмжээний өөрчлөлтөө мэдүүлсэн 31 албан тушаалтны мэдүүлгийг хуульд заасан хугацаанд бүртгэн авч УИХ-ын Хууль зүйн байнгын хороонд эх хувиар нь хүргүүлсэн ба тус газрын 12 албан тушаалтан ашиг сонирхлын зөрчилтэй гэдгээ илэрхийлэх, зөрчил үүссэн тухай мэдэгдэл гаргасныг бүртгэж хүлээн авсан болно.

Засгийн газрын шинээр байгуулагдсан яамдын дэд сайд, төрийн нарийн бичгийн дарга нар болон шинээр томилогдсон агентлагын дарга нарын судалгааг тухай бүр гаргаж, шинээр томилогдсон 62 албан тушаалтанд хуульд заасан хугацаанд мэдүүлгээ гаргах талаар сануулж, мэдүүлгийг хугацаанд нь гаргуулан авч бүртгэлээ.

Орон нутгийн сонгуулийн ажилтай холбогдуулан сонгуульд нэр дэвшигчдийн хөрөнгө, орлогын мэдүүлгийн маягтыг бөглөх загвар жишээг боловсруулж, газрын цахим хуудсанд байршуулсан ба аймаг, сум, дүүргийн сонгуулийн хорооны ажилтнууд болон сонгуульд нэр дэвшигчдэд загвар жишээг хүргүүлж, мэдээллээр хангах ажлыг зохион байгуулах талаар Сонгуулийн ерөнхий хороонд албан бичиг хүргүүлсэн. Улсын Их Хурлын сонгууль, нийслэлийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын сонгуультай холбогдуулан сонгуульд нэр дэвшигчийн мэдүүлгийг бүртгэн авч, хяналт тавих талаар Сонгуулийн ерөнхий хорооны удирдах албан тушаалтнууд болон эрх бүхий албан тушаалтантай байнга хамтран ажиллаж Улсын Их Хурлын сонгуульд сонгогдсон 72 сонгогдогчийн хөрөнгө, орлогын мэдүүлгийг хүлээн авсан ба аймаг, нийслэлийн Засаг дарга, ИТХ-ын дарга нарт хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг гаргаж ирүүлж байх талаар зөвлөмж хүргүүлэв.

Бүрдүүлэлтийн хяналт шалгалтын ажлыг эрчимжүүлэв. 2012 онд Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, Авлигын эсрэг хуулийн үйлчлэлд хамаарах албан тушаалтнуудын хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлгийг татан авч нарийвчлан шалгах ажлыг холбогдох хууль, тогтоомжийн дагуу хийж гүйцэтгэлээ.

Бүрдүүлэлтийн хяналт шалгалтын чиглэлээр Мэргэжлийн хяналтын ерөнхий газар, Газрын тосны газар, Мэдээллийн технологи, шуудан, харилцаа холбооны газар, Нийслэлийн мэргэжлийн хяналтын газар, Газрын харилцаа, геодези, зураг зүйн газар, Төрийн өмчийн хороо, Нийгмийн халамж үйлчилгээний ерөнхий газар зэрэг 7 байгууллагын давхардсан тоогоор 1199 албан тушаалтны мэдүүлгийг хянаж, мэдүүлгийн бүрдүүлэлтээр нийт 809 зөрчил илрүүлэв.

Хяналт шалгалтын ажлын хүрээнд 2012 онд нийт **238** албан тушаалтны мэдүүлгийг нарийвчлан шалгаснаас **192** албан тушаалтны мэдүүлгийг хянан шалгах ажиллагааг дуусгав.

Мэдүүлгийн зөрчлийн асуудлаар **41** албан тушаалтанд сануулах, **45** албан тушаалтанд албан тушаалын цалинг бууруулах, **4** албан тушаалтны албан тушаалыг бууруулах, **12** албан тушаалтныг ажлаас чөлөөлж, бусад арга хэмжээ **2**, бүгд **104** албан тушаалтанд хууль тогтоомжийн дагуу сахилгын шийтгэл ногдуулан хариуцлага тооцуулсан (Хүснэгт 2).

Хүснэгт 2. Хяналт шалгалтаар хариуцлага тооцуулсан албан тушаалтан 2011, 2012 оны байдлаар

Д/д	Хууль тогтоомжид зааснаар хариуцлага тооцуулсан арга хэмжээний төрөл	Харьцуулалт	
		2011 он	2012 он
1.	Сануулсан	55	41
2.	Цалинг бууруулсан	13	45
3.	Албан тушаал бууруулсан	2	4
4.	Ажлаас халсан буюу чөлөөлсөн	1	12
5.	Бусад арга хэмжээ	2	2
	Нийт	73	104

Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн дагуу нийтийн

албанд томилогдохоор нэр дэвшсэн этгээдийн хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг АТГ хянаж холбогдох байгууллагад дүгнэлт гаргах үйл ажиллагааг хариуцан ажиллаж байна. 2012 онд Засгийн газар шинэчлэн байгуулагдсан, Улсын Их Хурлын сонгууль, Орон нутгийн сонгууль болсонтой холбогдуулан нийтийн албанд томилогдохоор нэр дэвшсэн этгээдийн урьдчилсан мэдүүлгийг хянаж дүгнэлт гаргах үйл ажиллагаа эрчимжиж 7 хоногт **120-140** албан тушаалтны мэдүүлгийг хянаж хариу хүргүүлсэн бөгөөд 1 ажилтан дунджаар **360** орчим албан тушаалтны урьдчилсан мэдүүлгийг хянаж танилцуулга, зөвлөмж боловсруулж холбогдох байгууллага, албан тушаалтанд хүргүүлэв.

2012 онд нийтийн албанд томилогдохоор нэр дэвшсэн **3232** этгээдийн хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг хүлээн авснаас **3106** этгээдийн мэдүүлгийг хянаж холбогдох хариуг хүргүүлсэн. Хянаж хариу хүргүүлсэн **3106** этгээдийн урьдчилсан мэдүүлгээс Ашиг сонирхлын зөрчил үүсэж болохуйц нөхцөл байдлыг тогтоосон, анхааруулсан нийт **274**, хянах боломжгүй үндэслэлээр **190** мэдүүлгийг буцаан хүргүүлсэн байна.

Нийтийн албанд томилогдохоор нэр дэвшсэн этгээдийн урьдчилсан мэдүүлгийг хянуулахгүйгээр нийтийн албанд томилдог, томилсны дараа мэдүүлгийг хянуулахаар ирүүлдэг, өөр маягтаар мэдүүлгийг хүлээн авдаг, мэдүүлэгт хавсаргахаар заасан холбогдох материалыг бүрэн гүйцэд ирүүлдэггүй зэрэг хууль зөрчигдөх асуудал гарч байгааг анхааруулан, урьдчилсан мэдүүлэгтэй холбоотой асуудлаар Улсын бүртгэлийн ерөнхий газар, Цагдаагийн ерөнхий газар, Хөдөлмөрийн яам, орон нутгийн байгууллагад зөвлөмж хүргүүлэн ажиллав.


I.3 Иргэд, байгууллагаас ирсэн гомдол, мэдээллийг хянан шалгах чиглэлээр:

2012 онд хяналт шалгалтын үйл ажиллагааны үр дүнг тайлагнах, дүгнэлт гаргах, албан шаардлага, зөвлөмж хүргүүлэн хэрэгжилтийг хангуулах, хууль журам зөрчсөн асуудлаар хариуцлага тооцуулах чиглэлээр нийт **168** иргэдийн өргөдөл, гомдлыг хүлээн авснаас **161** өргөдөл гомдлыг хянан шийдвэрлэсэн. Өнөөдрийн байдлаар **7** өргөдөл, гомдлын үлдэгдэлтэй байна. Хянан шийдвэрлэсэн **161** өргөдөл, гомдлоос холбогдох арга хэмжээ авахуулахаар **78**, харъяаллын дагуу холбогдох Төрийн байгууллагад шилжүүлсэн **9**, гомдол гаргагч гомдлоосоо татгалзсан **8**, Шалгалтын явцад гэмт хэргийн шинжтэй зөрчлийг шалгуулахаар дотооддоо болон Цагдаагийн байгууллагад шилжүүлсэн **17**, бусад **49** гомдлыг тус тус шийдвэрлэсэн байна.

Иргэдээс гаргасан өргөдөл, гомдлын агуулгыг зөрчлийн хэлбэрээр нь авч үзвэл иргэдэд үзүүлэх төрийн үйлчилгээтэй холбоотой хүнд суртал чирэгдэл гаргадаг, албан тушаалтны ёс зүйн зөрчил гаргасан талаар **21** буюу 12 хувийг, албан тушаалын эрх мэдлээ хэтрүүлсэн, урвуулан ашигласан байж болзошгүй талаар **28** буюу 17 хувийг, хууль тогтоомж зөрчсөн, хууль бус үйлдэл гаргасан

талаар **74** буюу 44 хувийг, албан тушаалтны ашиг сонирхлын зөрчил болон хөрөнгө, орлогын мэдүүлгийг шалгуулахаар хандсан **45** буюу 27 хувийг тус тус эзэлж байна (Зураг 2.).

Зураг 2. Өргөдөл гомдлын агуулгын зөрчлийн хэлбэр



Хяналт шалгалтын ажлын явцад илэрсэн зөрчил дутагдлыг засуулах, төрийн байгууллагын авлига, хүнд суртлыг арилгах, төрийн үйлчилгээг иргэдэд ил тод нээлттэй, хөнгөн шуурхай болгох, төрийн албан хаагч нарын ёс зүй, харьцааны соёлыг дээшлүүлэх, үйл ажиллагааны доголдол, дутагдлыг засах шаардлагыг төрийн байгууллага, орон, нутгийн байгууллагын удирдлага, албан тушаалтнуудад албан бичиг, зөвлөмж хүргүүлж шийдвэрлүүлсэн байна. “Хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлгийн мэдээллийн систем”-ийн холбогдох нэмэлт өөрчлөлтийн ажлуудыг хийж гүйцэтгэн, Хөрөнгө, орлогын мэдүүлгийн бүрдүүлэлтийн програм хангамжийг 2012 оны бүрдүүлэлтийн үйл ажиллагаанд ашиглахаар ажиллаж байна.


I.4 Хуулиар харьяалуулсан гэмт хэрэгт явуулсан мөрдөн байцаалтын чиглэлээр:

Монгол Улсын Эрүүгийн байцаан шийтгэх хуульд заасан харьяаллын 293 холбогдогчтой 534 үйлдэлтэй, 164 эрүүгийн хэрэгт мөрдөн байцаалтын ажиллагаа явуулсан нь 2011 оны мөн үетэй харьцуулахад 13.4 хувиар өссөн байна. Эрүүгийн хэрэгт нийт 293 хүн сэжигтэн, яллагдагчаар татагдан шалгагдсан нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 6.3 хувиар буурсан байх бөгөөд холбогдогчдыг албан

тушаалын байдлаар авч үзвэл төрийн улс төрийн 29 буюу 9.8 хувь, төрийн захиргааны 66 буюу 22.5 хувь, төрийн тусгай 20 буюу 6.8 хувь, төрийн үйлчилгээний 48 буюу 16.3 хувь, энгийн буюу аж ахуйн нэгж, байгууллагын албан тушаалтан 129 буюу 44 хувь, гадаадын иргэн 1 буюу 0.3 хувийг эзэлжээ.

Мөрдөн байцаалт явуулсан нийт хэрэг, үйлдлийг Эрүүгийн хуулийн зүйл, хэсгээр ангилвал төрийн албан тушаалтан албаны эрх мэдэл буюу албан тушаалын байдлаа урвуулах 43 буюу 21.0 хувь, төрийн албан тушаалтан эрх мэдлээ хэтрүүлэх 24 буюу 11.7 хувь, төрийн бус байгууллага, аж ахуйн нэгжийн албан тушаалтан эрх мэдлээ урвуулах 13 буюу 6.0 хувь, төрийн бус байгууллага, аж ахуйн нэгжийн албан тушаалтан эрх мэдлээ хэтрүүлэх 3 буюу 1.4 хувь, хээл хахууль авах 24 буюу 11.7 хувь, хээл хахууль өгөх 19 буюу 9.3 хувь, хээл хахуульд зуучлах 4 буюу 1.9 хувь, төсвийн хөрөнгийг зориулалтын бусаар зарцуулах 10 буюу 4.9 хувь, бусад 64 буюу 31.3 хувийг эзэлж байна (Зураг 3).

Зураг 3. Мөрдөн байцаалт явуулсан гэмт хэрэг /төрлөөр/



Мөрдөн шалгасан эрүүгийн хэргийн шийдвэрлэлтийг авч үзвэл 33 хэргийг буюу нийт шалгасан хэргийн 20.1 хувийг яллах дүгнэлт үйлдүүлэхээр шилжүүлсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 23.2 хувиар буурсан, 33 хэргийг буюу 20.1 хувийг хэрэгсэхгүй болгох саналтайгаар шилжүүлсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 5,7 хувиар буурсан, 25 хэргийг буюу 15.2 хувийг харьяаллын дагуу шилжүүлсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 7.4 хувиар буурсан, 24 хэргийг

буюу 14.6 хувийг өөр эрүүгийн хэрэгт нэгтгэж, 2 хэргийн мөрдөн байцаалтын ажиллагааг түдгэлзүүлсэн байна.


Хэрэгсэхгүй болгосон хэргийн 6-н хэргийг харьяаллын дагуу хүлээн авсан, 5 хэргийг эрүүгийн хэрэг үүсгэхээс татгалзсан материалд прокурор үүсгэсэн байх бөгөөд 1 хэргийг өөр эрүүгийн хэргээс тусгаарлаж хэрэгсэхгүй болгосон байна. Бусад 21 эрүүгийн хэргийг тус газрын мөрдөн байцаагч нар гомдол, мэдээллээр хүлээн авч эрүүгийн хэрэг үүсгэж шалгаснаас хөөн хэлэлцэх хугацаа дууссан үндэслэлээр 3 хэргийг, гэмт хэрэг үйлдсэн нь нотлогдоогүй үндэслэлээр 1 хэргийг, гэмт хэргийн бүрэлдэхүүнгүй үндэслэлээр 16 хэргийг, хохирогчтой эвлэрсэн үндэслэлээр 1 хэргийг хэрэгсэхгүй болгосон байна.

2012 оны 12 дугаар сард ажиллагаанд **47** эрүүгийн хэргийн үлдэгдэлтэй байна.

Эрүүгийн хэрэгт татагдан шалгагдсан холбогдогчийг өмнөх оны мөн үетэй харьцуулбал төрийн улс төрийн албан тушаалтан 5 буюу 17.2 хувиар өссөн, төрийн захиргааны албан тушаалтан 2 буюу 2.9 хувиар буурсан, төрийн тусгай албан тушаалтан 5 буюу 20 хувиар буурсан, төрийн үйлчилгээний албан тушаалтан 18 буюу 27.2 хувиар буурсан байна.

Яллах дүгнэлт үйлдүүлэхээр шилжүүлсэн эрүүгийн хэрэгт нийт **116** хүнийг яллагдагчаар татсан байх бөгөөд тэдгээрийн албан тушаалын ангиллаар нь авч үзвэл төрийн улс төрийн **10** буюу 8.6 хувь, төрийн захиргааны **27** буюу 23.2 хувь, төрийн тусгай **10** буюу 8.6 хувь, төрийн үйлчилгээний **22** буюу 18.9 хувь, энгийн **47** буюу 40.5 хувийг эзэлж байна (Зураг 4).

Зураг 4. Сэжигтэн, яллагдагч /албан тушаалын ангиллаар/



Албан тушаалтнуудыг зүйлчлэлээр нь авч үзвэл төрийн албан тушаалтан албаны эрх мэдэл буюу албан тушаалын байдлаа урвуулах **12**, төрийн албан тушаалтан эрх мэдлээ хэтрүүлэх **10**, төрийн бус байгууллага, аж ахуйн нэгжийн албан тушаалтан эрх мэдлээ урвуулах **2**, хээл хахууль авах **12**, хээл хахууль өгөх **8**, хээл хахуульд зуучлах **3**, төсвийн хөрөнгийг зориулалтын бусаар зарцуулах **5**, бусад **27** байна.

Яллах дүгнэлт үйлдүүлэхээр шилжүүлсэн хэргээс **38** шүүгдэгчид холбогдох **12** хэрэг шүүхээр шийдвэрлэгдэж **26** шүүгдэгчийг гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд тооцон **21** шүүгдэгчийг хорих ялаар, **2** шүүгдэгчийг торгох ялаар, **7** шүүгдэгчийг баривчлах ялаар, **1** шүүгдэгчийг тодорхой ажил, албан тушаал эрхлэх нэмэгдэл ялаар шийтгэж, хорих ял оногдуулсан **2** шүүгдэгчийн ялыг Өршөөл үзүүлэх тухай хуульд заасан үндэслэлээр эрүүгийн хариуцлагаас чөлөөлж, **2** шүүгдэгчийн хорих ялыг тэнсэж, баривчлах ял оногдуулсан **2** шүүгдэгчийн баривчлах ялыг тэнссэн байна. Мөн **4** шүүгдэгчийг гэм буруутайд тооцож Өршөөлийн хуульд заасан үндэслэлээр эрүүгийн хариуцлагаас чөлөөлж үйлдсэн хэргийг хэрэгсэхгүй болгосон бол, **1** шүүгдэгчийг шүүхээс гэм буруутайд тооцож эрүүгийн хариуцлага хүлээлгэх хөөн хэлэлцэх хугацаа дууссан үндэслэлээр хэргийг хэрэгсэхгүй болгосон байна. Харин **3** шүүгдэгчид холбогдох **2** хэргийг хэрэгсэхгүй болгож, шүүгдэгч нарыг цагаатгасан байна.

Энэ хугацаанд мөрдөн шалгасан нийт эрүүгийн хэрэгт **38** тэрбум төгрөгийн хохирол учирсан байх бөгөөд **3.1** тэрбум төгрөгийн хохирлыг мөрдөн байцаалтын явцад нөхөн төлүүлсэн нь өмнөх оноос **64.5** хувиар, **3.9** тэрбум төгрөгийн эд хөрөнгийг битүүмжлэн хамгаалсан нь өмнөх оноос **23** хувиар тус тус өссөн байна.

2012 онд тус газрын мөрдөн байцаагчид хуулиар харьяалуулсан албан тушаалын гэмт хэрэг мөн болохыг нь гэмт хэргийн бүрэлдэхүүний талаас нь бүрэн гүйцэд шалган баримтаар нотолж ажилласны үр дүнд хэрэгсэхгүй болгох саналтайгаар шилжүүлсэн, харьяаллын дагуу шилжүүлсэн эрүүгийн хэргийн тоог бууруулж, нийт мөрдөн шалгасан эрүүгийн хэргийн тоо өмнөх оныхоос өсөхөд нөлөөлсөн байна.

Харин мөрдөн байцаагчид эрүүгийн хэргийг мөрдөн шалгахдаа аливаа этгээдийн буруутай үйл ажиллагааг нотлох баримтуудаар нотлон тогтоосны эцэст тэднийг эрүүгийн хэрэгт сэжигтэн, яллагдагчаар татах зарчмыг баримтлан ажилласнаар хэрэгт сэжигтэн, яллагдагчаар холбогдон шалгагдсан холбогдогчийн тоо буурахад нөлөөлжээ.

Мөн үйлдэл, холбогдогч ихтэй, зохион байгуулалттай, төрийн, аж ахуйн нэгжийн, улс төрийн байгууллагын эрх мэдэл, нөлөө бүхий албан тушаалтнууд холбогдсон авлига, албан тушаалын томоохон хэргүүдийг илрүүлэх, мөрдөн шалгахад анхаарлаа хандуулан ажилласан нь яллах дүгнэлт үйлдүүлэхээр прокурорт шилжүүлсэн хэргийн тоон үзүүлэлтийг буурахад хүргэсэн байна.

Гэхдээ нөгөө талаас нь дүгнэхэд мөрдөн шалгаж, шийдвэрлэсэн эрүүгийн хэргийн өнгө, түүнд холбогдон шалгагдсан албан тушаалтнуудын ангилал

өөрчлөгдөж, шалгаж шийдвэрлэсэн хэргүүдтэй холбоотойгоор нийгмийн авлигатай тэмцэх хандлагад эерэгээр нөлөөлсөн.

Эрүүгийн хэрэгт татагдан шалгагдсан төрийн улс төрийн албан тушаалтны тоо өссөн нь төрийн өндөр албан тушаалтны үйлдсэн хэрэг, үйлдэлд анхаарал хандуулж ажилласны, харин төрийн захиргааны, төрийн тусгай, төрийн үйлчилгээний албан тушаалтны тоо буурсан нь тухайн салбарт чиглэсэн мөрдөн шалгах, авлигаас урьдчилан сэргийлэх ажил үр дүнгээ өгч байгаагийн илрэл гэж үзэж болно.

Мөрдөн шалгасан эрүүгийн хэрэгт нөхөн төлүүлсэн, битүүмжлэн хамгаалсан эд хөрөнгийн дүн өссөн нь мөрдөн байцаагчид эрүүгийн хэрэгт албан тушаалтнуудын нуугдмал хөрөнгийг олж илрүүлэх үйл ажиллагааг үр дүнтэй хэрэгжүүлсэн явдал юм.

Мөрдөн шалгах хэлтсээс харьяаллын авлига, албан тушаалын томоохон хэргүүдийг илрүүлэх, үр дүнтэй мөрдөн шалгаж эцэслэн шийдвэрлүүлэх, гэмт хэргийн улмаас иргэн, аж ахуйн нэгж, төрд учирсан хохирлыг нөхөн төлүүлэх, иргэний нэхэмжлэл, хохирсон эрхээ сэргээлгэх нэхэмжлэлийг хангах үүднээс эд хөрөнгийг битүүмжлэн хамгаалах асуудалд анхаарлаа хандуулан ажиллаж байна.

2012 онд нийт 845 гомдол, мэдээлэл хүлээн авсаныг байгууллагын “Гомдол, мэдээллийн нэгдсэн бүртгэл”-д, Мөрдөн Шалгах хэлтсийн гомдол, мэдээллийн бүртгэлд 345 гэмт хэргийн шинжтэй гомдол, мэдээлэл бүртгэгдсэн нь 2011 оны мөн үетэй харьцуулахад 17 хувиар буурсан байна.

Урд оны үлдэгдэл 12 гомдол, мэдээлэл, шинээр хүлээн авсан 345 нийт 357 гомдол, мэдээллийг хянан үзсэнээс 73 гомдол, мэдээлэл буюу 20.4 хувьд эрүүгийн хэрэг үүсгэсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 26 хувиар өссөн, 146 гомдол, мэдээлэл буюу 40.8 хувьд эрүүгийн хэрэг үүсгэхээс татгалзах санал гаргасан нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 31.7 хувиар буурсан, 124 гомдол, мэдээлэл буюу 34.7 хувийг харьяаллын дагуу шилжүүлж шийдвэрлэсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 24.3 хувиар буурсан үзүүлэлттэй байна. Мөн 1 гомдлыг эрүүгийн хэрэгт нэгтгэн шалгасан байх бөгөөд ажиллагаанд 13 гомдол, мэдээллийн үлдэгдэлтэй, шийдвэрлэлт 96.3 хувьтай байна.

Иргэд, байгууллагаас ирүүлсэн гомдол, мэдээллийн агуулга, холбогдох байгууллага, салбараар авч үзвэл нутгийн захиргааны болон өөрөө удирдах байгууллагын үйл ажиллагаанд хамаарах 93 /үүнээс 69 нь Засаг даргын үйл ажиллагаанд, 24 нь ЗДТГ-ын үйл ажиллагаанд/, хууль хяналтын байгууллагын үйл ажиллагаанд хамаарах 50 /үүнээс 12 нь цагдаа, 7 нь шүүх, 7 нь шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага, 11 нь мэргэжлийн хяналт, 4 нь гааль, 3 нь хил хамгаалах, 1 нь прокурор, 3 нь татвар, 1 нь онцгой байдлын асуудал эрхэлсэн байгууллага, 1 нь тагнуул/, боловсрол, эрүүл мэнд, төрийн үйлчилгээний салбарт хамаарах 47 /үүнээс 28 нь боловсрол, 10 нь эрүүл мэнд, 3 нь улсын бүртгэлийн албанд, 4 нь төрийн үйлчилгээний бусад салбарт/, газар, ашигт малтмалын салбарт хамаарах 23, яамдын үйл ажиллагаатай холбоотой 15, УИХ-ын гишүүнд холбоотой 8, төрийн болон орон нутгийн өмчит улсын үйлдвэрийн газрын үйл ажиллагаанд хамаарах 27,

банк санхүүгийн салбарт хамаарах 1, аж ахуйн нэгжийн үйл ажиллагаанд хамаарах 34, бусад салбарт хамаарах 48 байна.

Эдгээр гомдол, мэдээллийг хүлээн авсан хэлбэрээр нь ангилбал бичгээр 203, утсаар 12, шуудангаар 113, интернетээр 6, биечлэн 6, факсаар 5 гомдол, мэдээлэл иржээ.

Мөрдөн шалгах хэлтэст хүлээн авч шалгасан гэмт хэргийн шинжтэй гомдол, мэдээллийн тоон үзүүлэлт өмнөх оныхоос буурсан нь манай байгууллагад хуулиар харьяалуулсан албан тушаалын гэмт хэргийн тухай гомдол, мэдээлэл мөн эсэхэд анхаарч, гэмт хэргийн шинжгүй болон харьяаллын бус гомдол мэдээллийг Авлигын эсрэг хуулийн 18 дугаар зүйлийн 18.4.1, ЭБШХ-ийн 172 дугаар зүйлийн 172.1.3 дахь зүйлд зааснаар харьяалах төрийн болон хууль хяналтын байгууллагад шилжүүлж ажилласантай холбоотой юм.

Ингэж тус газарт иргэн, хуулийн этгээдээс ирүүлсэн гомдол, мэдээллийг хууль зүйн талаас нь үнэлж дүгнэсний эцэст харьяаллын албан тушаалын гэмт хэргийн шинжтэй гомдол мэдээллийг нь хүлээн авч шалгаж гэмт хэрэг үйлдэгдсэн эсэхийг тогтоон ажилласан нь эрүүгийн хэрэг үүсгэсэн тоон үзүүлэлтэд нөлөөлжээ. Энэ нь нөгөө талаасаа дан ганц иргэн, хуулийн этгээдээс ирүүлсэн гомдол мэдээллээр бус, тус газрын Гүйцэтгэх ажлын хэлтэс, Мөрдөн шалгах хэлтсийн үйл ажиллагааны уялдаа холбоо сайжирч харьяаллын гэмт хэргийг илрүүлэн шалгах ажилд ахиц гарсантай холбоотой.

Мөн анхнаас нь сайтар нягтлан хүлээн авсан гомдол, мэдээллийг шалгасан нь эрүүгийн хэрэг үүсгэхээс татгалзах санал гаргасан, харьяаллын дагуу шилжүүлж шийдвэрлэсэн гомдол, мэдээллийн тоо буурахад нөлөөлсөн эерэг үр дүн гарсан.

Иргэд, хуулийн этгээдээс Авлигатай тэмцэх газарт ирүүлсэн гэмт хэргийн шинжгүй болон харьяаллын бус гомдол мэдээллийг харьяалах төрийн байгууллагад шилжүүлэхдээ Авлигын эсрэг хуулийн 6 дугаар зүйлийн 6.6-д заасны дагуу тухайн төрийн байгууллагад гомдол мэдээллийг хэрхэн шийдвэрлэсэн талаар эргэж хариу мэдэгдэж байхыг бичгээр хүргүүлдэг боловч хариу мэдэгдсэн тохиолдол цөөхөн байгааг дурдах нь зүйтэй гэж үзэж байна.

I.5 Гадаад харилцааны чиглэлээр:

Гадаад арга хэмжээ, хамтын үйл ажиллагааны хүрээнд Авлигатай тэмцэх газар гадаад орны ижил төстэй чиг үүрэг бүхий байгууллагууд, олон улсын байгууллагуудтай хамтын ажиллагааг улам эрчимжүүлэх зорилгоо хэрэгжүүлэн ажилласан. Бүгд Найрамдах Австри Улсын Вена хотод 2010 оны 9 дүгээр сарын 02-ны өдөр байгуулсан “Авлигын эсрэг олон улсын академийг олон улсын байгуулага болгон үүсгэн байгуулах тухай хэлэлцээр”-т Монгол Улсын Засгийн газрын өргөн мэдүүлснээр нэгдэн орох тухай Монгол Улсын хуулийг Улсын Их Хурлаас 2012 оны 12 дугаар сарын 05-ны өдөр баталсан нь тус байгууллагын ажилтан, албан хаагчдыг олон улсын түвшинд сургах, хүний нөөцийн чадвар, чадамжийг бэхжүүлэхэд чиглэсэн чухал алхам боллоо.

Монгол Улсын Авлигатай тэмцэх газар нь БНСУ-ын Авлигын эсрэг, иргэний эрхийн комисс, БНХАУ-ын Авлигаас урьдчилан сэргийлэх үндэсний газар, Тайландын Авлигын эсрэг үндэсний комисстой байгуулсан хамтран ажиллах харилцан ойлголцлын санамж бичгийг хэрэгжүүлж байна. Авлигатай тэмцэх газрын дарга БНХАУ-ын Хянан шалгах яамны сайд, Авлигаас урьдчилан сэргийлэх үндэсний товчооны даргын урилгаар тус улсад хийсэн албан ёсны айлчлал, Тайландын Вант Улсад Дэлхийн банкнаас зохион байгуулагдсан хурал, Тайландын Вант Улсын Авлигатай тэмцэх хорооны удирдлагатай хийсэн уулзалт, Австрали Улсад зохион байгуулагдсан Олон улсын мөнгө угаах гэмт хэрэгтэй тэмцэх байгууллагын хурал болон Сингапур Улсын Авлигатай тэмцэх газартай харилцаа тогтоох уулзалт, Хонг Конгд зохиогдсон авлигын эсрэг симпозиумд оролцох болон Хонг Конгийн Авлигатай тэмцэх газрын удирдлагуудтай хийсэн ажил хэргийн уулзалтуудад амжилттай оролцож, тодорхой асуудлаар санал солилцон хамтран ажилласан.

Мөн БНХАУ, БНСУ, Малайз, Сингапур, Хонг Конг, Бутан зэрэг улс орнуудын Авлигатай тэмцэх байгууллагуудтай харилцаа холбоогоо сэргээх ажлыг эрчимжүүлснээс гадна НҮБ-ын хар тамхи, гэмт хэрэгтэй тэмцэх алба, Дэлхийн банк, Азийн хөгжлийн банк, Канадын Төрийн албаны хороо, Авлигатай тэмцэх байгууллагуудын олон улсын холбоо зэрэг байгууллагуудтай харилцаа тогтоон ажиллаж байна.

**ХОЁРДУГААР ХЭСЭГ: МОНГОЛ УЛСЫН АВЛИГЫН ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ
БАЙДЛЫН ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ**

II.1 Монгол Улс дахь авлигын ерөнхий нөхцөл байдал

Монгол Улсын авлигын нөхцөл байдлын талаар төрөл бүрийн судалгаа хийгддэг. Монгол Улс дахь авлигын ерөнхий нөхцөл байдлыг олон улсын байгууллагуудын үнэлгээ буюу Дэлхийн нийтийн авлигын төлөв байдал, олон улсын түвшин дэх Монгол Улсын авлигатай тэмцэх үйл ажиллагааны үнэлгээг Транспэрэнси Интернэшнл байгууллагаас гаргадаг Авлигын төсөөллийн индекс, Хууль дээдлэх ёсны 2012 оны индексийн судалгаа болон үндэсний хэмжээнд хийгддэг бусад судалгааны үр дүнд үндэслэн тодорхойлон танилцуулж байна.

Авлигын төсөөллийн индекс¹: Олон улсын хэмжээнд дэлхийн улс орнуудын авлигын түвшин хэрхэн өөрчлөгдөж байгааг харьцуулан үнэлгээ гаргадаг Транспэрэнси Интернэшнл байгууллагын Авлигын төсөөллийн индексийг 0-100 хүртэл оноогоор үнэлдэг байсныг 2012 оноос эхлэн 0 (авлигад маш ихээр автсан) 100 (авлигагүй) хүртэл оноогоор үнэлдэг болсон.

Авлигын төсөөллийн индекс-2012 судалгааны аргачлал өөрчлөгдсөнөөр цаашид Авлигын төсөөллийн үнэлгээ харьцуулахуйц болж байгаагаар онцлог юм. Өөрөөр хэлбэл, өмнөх судалгааны үр дүнгээр гарч буй нэг улсын үнэлгээ нь цаг хугацааны өөрчлөлтийг харуулж чадахгүй байсан юм. Энэхүү аргачлалд өөрчлөлт орсноор 2013 оноос эхлэн цаг хугацааны өөрчлөлтийг нэг улсын хувьд илэрхийлэх үнэлгээтэй болж байгаа юм (2011 оны үнэлгээг 2012 оны үнэлгээтэй харьцуулж болохгүй²).

2012 оны судалгаанд 174 орныг хамруулснаас гуравны хоёр нь тавиас доош үнэлгээтэй гарчээ. Монгол Улсын хувьд 2012 онд Авлигын төсөөллийн индексийн утга 36 гэсэн үнэлгээгээр 94 дүгээр байрт орж урагшиллаа. Монгол Улсын хамт Бенин, Колумб, Жибути, Грек, Энэтхэг, Молдав, Сенегал улс орж байна (Хүснэгт 3).

Хүснэгт 3. Авлигын төсөөллийн индексийн утга болон үнэлгээнд хамрагдсан улс орнууд дунд эзлэх байр

	2006	2007	2008	2009	2010	2011	2012 ³
Авлигын төсөөллийн индексийн утга	2.8	3.0	3.0	2.7	2.7	2.7	36
Монгол Улсын эзэлж буй байр	99	99	102	120	116	120	94
Үнэлгээнд хамрагдсан улс	163	179	180	180	178	182	174

¹ <http://www.transparency.org/cpi2012/results> (хандалт 2013 оны 1 дүгээр сарын 21-ны өдөр)

² http://www.transparency.org/files/content/pressrelease/2012_CPIUpdatedMethodology_EMBARGO_EN.pdf (Хандалт 2013 оны 1 дүгээр сарын 21-ны өдөр)

³ 2012 оноос эхлэн үзүүлэлтийг 0-100 оноогоор дүгнэдэг болсон.

Транспэрэнси Интернэшнл байгууллагаас улс орнуудын Авлигын төсөөллийн индексийг тооцохдоо нийт 13 төрлийн мэдээллийн эх үүсвэрийг ашигладаг. Монгол Улсын авлигын төсөөллийн 2012 оны индексийг тооцоолохдоо дор дурдсан 7 төрлийн судалгааны үр дүнг ашигласан байна. Үүнд:

Бертелсманы сангийн Эрс шинэчлэлтийн индекс 32, Дэлхийн эдийн засгийн форумас гаргадаг Дэлхийн өрсөлдөх чадварын үнэлгээ 26, Дэлхийн Банкнаас гаргадаг Улс орнуудын бодлогын үнэлгээ 47, Глобал Инсайт байгууллагаас гаргадаг Улс орнуудын эрсдлийн үнэлгээ 42, Экономист Интеллиженс Юнит байгууллагаас гаргадаг Улс орнуудын эрсдлийн үнэлгээ 38, Политикал Риск Сервисес байгууллагын Интернейшнл каунтри риск гийд үнэлгээ 31, World Justice Project байгууллагын Хууль сахин биелүүлэх байдлын индекс 37 гэж үнэлэгдсэн байна. Дэлхийн эдийн засгийн форумын өрсөлдөх чадварын үнэлгээ нь гадаад худалдаа, нийгмийн үйлчилгээ, татвар хураалт, төсвийн хөрөнгөөр хийж буй худалдан авалт, шүүхийн шийдвэр гаргах зэрэг үйл ажиллагаатай холбоотой баримтгүй нэмэлт төлбөр, хээл хахуулийн нөхцөл байдлын талаарх бизнес эрхлэгчид, дотоод, гадаадын компаниудын үнэлгээ⁴ бөгөөд Монгол Улс энэхүү үнэлгээгээр харьцангуй доогуур буюу 26 гэсэн үнэлгээтэй гарсан байна.

Хууль дээдлэх ёсны индекс⁵: Дэлхийн хууль дээдлэх ёсны төсөл нь ашгийн бус, бие даасан байгууллага юм. Тус байгууллага нь дэлхийн улс орнууд бодит амьдрал дээр хууль, эрх зүйт төр, нийгмийн талаарх үнэлгээг бүс нутгийн болон дэлхийн хэмжээнд 0 (авлига их)-ээс 1(авлигагүй) хүртэл үнэлгээгээр гаргадаг бөгөөд үндсэн 9 үзүүлэлт буюу засгийн газрын эрх мэдлийн хязгаарлалт, авлигаас ангид байдал, хэв журам ба аюулгүй байдал, үндсэн эрх чөлөө, засгийн газрын нээлттэй байдал, зохицуулалтын хэрэгжилт, захиргааны эрх зүй, эрүүгийн эрх зүй, албан бус зохицуулалт зэрэг юм. Монгол Улсын хувьд хөгжиж буй орнуудын дунд хэв журам ба аюулгүй байдал, үндсэн эрх чөлөө хамгаалагдсан байдал зэрэг үзүүлэлтээр 5 дугаар байранд байна. Түүнчлэн захиргааны болон эрүүгийн эрх зүйгээр Монгол Улс нь харьцангуй сайн үнэлэгдсэн бөгөөд хэвлэл мэдээллийн хэрэгсэл болон төрийн бус байгууллагууд засгийн газрын оролцоогүй үйл ажиллагаа эрхэлдэг гэсэн байна. Гэвч засгийн газрын нээлттэй байдал гэсэн үзүүлэлтээр судалгаанд хамрагдсан 97 орноос 93 байранд, хөгжиж буй орнуудын дунд тус үзүүлэлтээр сүүлээсээ хоёр дахь байранд орсон байна. Энэ нь “иргэдийн засгийн газарт өргөдөл, хүсэлт гарган шийдвэрлүүлэх байдал болон албан ёсны мэдээлэл авах эрх хязгаарлагдмал байдагт оршиж байна. Түүнчлэн засгийн газрын бүх салбарт нөлөөлж буй хяналтгүй эрх мэдэл бүхий хувийн ашиг сонирхол” хэмээн тус тайланд Монгол Улсын талаар дурджээ. Гүйцэтгэх засаглал болон шүүх засаглал дахь авлигын түвшин, түүнчлэн цагдаа болон батлан хамгаалах салбар

⁴ “Corruption Perceptions Index: Sources of Information”, Transparency International

⁵ <http://worldjusticeproject.org/>, (Хандалт 2013 оны 1 дүгээр сарын 22-ны өдөр)

дахь авлигын түвшин хөгжиж буй орнуудын ижил түвшинд байгаа бол Зүүн өмнөд азийн орнуудаас доогуур, түүнчлэн хууль сахиулах байгууллагын авлигын асуудал маш тааруу үнэлгээ авсан байна.

Харин Авлигатай тэмцэх газраас зохион байгуулж явуулдаг Улс төр, хууль хяналтын байгууллага дахь авлигын төсөөлөл-2012 оны судалгаагаар Хууль хяналтын байгууллага дахь авлигын төсөөлөл 3.58 болж 2011 оны судалгааны үр дүнтэй харьцуулахад 0.37 пунктээр авлигын эрсдэл буурсан байна. Хэдийгээр үндэсний судалгааны дүнгээр авлигын төсөөлөл буурч байгаач олон улсын судалгааны үр дүнгээр тааруу байгаад анхаарах нь зүйтэй юм.

Бизнес эрхлэлтийн орчин дахь авлигын нөхцөл⁶: “Төр болон бизнес эрхлэгчдийн хоорондох харилцаанд авлига хэрхэн нөлөөлж байгаа талаар ямар нэгэн судалгаа, мэдээлэл өнөөг хүртэл Монгол Улсад хийгдээгүй байсан”⁷. АНУ-ын Азийн сангийн дэмжлэгтэйгээр Сант марал сан 2012 оны 4 дүгээр улиралд “Бизнес эрхлэлтийн орчин дахь авлигын нөхцөл байдал” судалгааг зохион байгуулж явуулсан юм. Энэхүү судалгаа нь хоёр жилийн хугацаанд хийгдэх дөрвөн судалгааны эхнийх бөгөөд судалгааг үе шаттай хийснээр бизнес эрхлэгчдийн төсөөллөөр авлига хэрхэн өөрчлөгдөж байгааг тухай бүрт тогтоох боломжтой. Тус судалгааны дүнгээр авлигыг бууруулах хамгийн шилдэг гурван аргаар шударга зарчмаар ажиллах (62.7%), Засгийн газрын үйл ажиллагааны талаарх хууль дүрмийн мэдлэгтэй байх болон авлигач улс төрчдийн эсрэг компанит арга хэмжээ явуулах (40.3%) аргуудыг нэрлэсэн байна (Зураг 5).

Зураг 5. Авлигыг бууруулах арга зам



Мөн бизнесийн хөгжилд хамгийн ихээр тулгардаг саад бэрхшээлүүдийг үнэлсэн бөгөөд жижиг бизнесийнхний хувьд татвар (61.3%), мөн дунд бизнес

⁶ Бизнес эрхлэлтийн орчин дахь авлигын нөхцөл байдал судалгааны тайлан, Улаанбаатар 2013, Азийн сан,

⁷ Мөн тэнд

эрхлэгчдийн зөвшөөрөл, лиценз олголт болон сунгалтад (30.8%), төрийн албан хаагчдын мэргэжлийн ур чадвар хангалтгүй (25.6%) зэрэг багтаж байна (Хүснэгт 4).

Хүснэгт 4. Бизнесийн үйл ажиллагаан дахь гол бэрхшээлүүд, дүнд эзлэх хувиар

	Жижиг	Дунд	Том
Өндөр татвар	61.3	54.1	59.6
Албан хураамж	16.7	16.5	12.8
Албан бус хураамж	21.3	14.3	10.6
Түр зуурын хориг, саад	12.7	17.3	19.1
Байнгын хориг, саад	9.3	13.5	8.5
Мэдээллийн хүртээмж ба чанар	10.0	9.8	10.6
Зөвшөөрөл, лиценз олголт ба сунгалт	34.7	30.8	38.3
Ажиллах хүчний мэргэжлийн чадвар хангалтгүй	17.3	25.6	36.2


Судалгаагаар бизнесийн үйл ажиллагаанд хамгийн их саад учруулж байгаа байгууллагуудыг тодорхойлсон юм. Энэ удаагийн судалгаагаар татвар (34.5%), мэргэжлийн хяналт (27.3%), гаалийн байгууллага (14.8%) бизнес эрхлэгчдэд хамгийн их саад тотгор учруулж байна гэж судалгаанд оролцогчид үзжээ (Зураг 6).

Зураг 6. Бизнесийн үйл ажиллагаанд хамгийн их саад учруулж байгаа байгууллагууд




Судалгааны дүнгээр жижиг, дунд бизнес эрхлэгчидтэй харьцуулахад том бизнес эрхлэгчид өөрсдийн нөөц бололцооныхоо ихэнх хувийг үр ашиггүй, хүнд суртал бүхий үйл ажиллагаанд зарцуулдаг ба том бизнес эрхлэгчдийн 17.0 хувь нь ажлын цагийнхаа 50-иас дээш хувийг үйлдвэрлэлийн бус саад бэрхшээлүүдийг шийдвэрлэхэд зарцуулдаг бол жижиг бизнес эрхлэгчдийнх 13.3 хувь, дунд хэмжээний бизнес эрхлэгчдийнх 9.0 хувь байлаа (Зураг 7).

Зураг 7. Танай байгууллагын удирдлага үйлдвэрлэлийн бус асуудлуудыг шийдвэрлэхэд ажлын цагийн хэдэн хувийг зарцуулдаг вэ? хувь, компанийн хэмжээгээр



Засгийн газраас авч хэрэгжүүлж байгаа авлигын эсрэг үйл ажиллагаа, хүчин чармайлтын талаар бизнес эрхлэгчдийн 44.0 хувь нь бага зэрэг мэддэг гэсэн бол 29.0 хувь нь бараг ямар ч мэдээлэлгүй гэж хариулжээ (Зураг 8).

Зураг 8. Та одоогийн ЗГ-аас явуулж байгаа явлигын эсрэг үйл ажиллагааны талаар хэр сайн мэдэх вэ?



Монгол Улсын Авлигын индекс: Авлигын эсрэг хуулийн 18 дугаар зүйлд заагдсан Авлигатай тэмцэх газрын чиг үүрэгт авлигын цар хүрээ, хэлбэр, шалтгааныг 2 жилд нэгээс доошгүй удаа судлан **Авлигын индекс** гаргаж олон нийтэд мэдээлэхээр заасан. Үүний дагуу Авлигатай тэмцэх газар Монгол Улсын авлигын индексийг гарган олон нийтэд мэдээлдэг. Авлигатай тэмцэх газрын хийсэн 2011 оны судалгааны дүнгээр Монгол Улсын авлигын индекс **0.63** гарсан байна. Монгол Улс огт авлигагүй улс болсон үед авлигын индекс **1.0** болно гэж үзвэл одоо бид хаана явж байгаагаа төсөөлөх боломжтой. Монгол Улсын Авлигын индексийн судалгааг 2 жил тутам 1 удаа хийж индекс гаргадаг тул дараагийн судалгааг 2013 онд хийнэ.

Төрийн байгууллагын шударга байдлын түвшний үнэлгээ: Монгол Улсын Авлигын эсрэг хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.7-д “төрийн үйлчилгээ авсан иргэд, байгууллагын судалгаанд тулгуурлан төрийн байгууллагын шударга байдлын түвшинд 2 жил тутамд үнэлгээ гаргаж, олон нийтэд мэдээлэх”-ээр заасны дагуу төрийн байгууллагын шударга байдлын түвшний үнэлгээг судалгаанд хамруулахаар сонгож авсан төрийн үйлчилгээний байгууллагуудаар үйлчлүүлсэн 2499 иргэнийг хамруулсан “Төрийн үйлчилгээ авсан иргэдийн 2012 оны судалгаа”-ны үр дүнд үндэслэн тооцсон.⁸ Товчхондоо төрийн байгууллагын шударга байдлын түвшний үнэлгээ хэр сайн гарна, тэр хэмжээгээр төрийн байгууллагад авлига бага байна гэж үзэх боломжтой. Төрийн байгууллагын шударга байдлыг үнэлэх судалгааг 2 дахь удаа явуулж төрийн үйлчилгээ авсан иргэдийн 2012 оны судалгааны үр дүнд үндэслэн төрийн үйлчилгээний 10 салбарын шударга байдлын түвшинг тодорхойлсон. Төрийн үйлчилгээний салбаруудын дунджаар төрийн байгууллагын шударга байдлын түвшний үнэлгээ (1-5 хүртэлх үнэлгээгээр) 3.38 гарсан нь 2010 оны судалгааны үр дүнгээс 0.61 пунктээр өссөн байна (Хүснэгт 5)⁹.

Хүснэгт 5. Төрийн байгууллагын шударга байдлын түвшний үнэлгээ

Салбар	Шударга байдлын түвшний үнэлгээ		Зөрүү
	2010	2012	
Эрүүл мэндийн байгууллага	2.70	3.24	0.54
Боловсролын байгууллага	2.88	3.54	0.66
Хөдөлмөр, халамж үйлчилгээний байгууллага	2.84	3.40	0.56
Нийгмийн даатгалын байгууллага	2.91	3.61	0.70
Газрын алба	2.70	3.22	0.52
Татварын байгууллага	2.99	3.58	0.59
Улсын бүртгэлийн байгууллага	2.73	3.36	0.63
Гаалийн байгууллага	2.89	3.83	0.94
Мэргэжлийн хяналтын байгууллага	2.80	3.32	0.52

⁸ http://www.iaac.mn/pdf/ssh/turiin_baiguullaga_shudarga_2012.pdf

⁹ “Монгол Улсын төрийн байгууллагын шударга байдлын түвшинг үнэлэх 2012 оны судалгааны тайлан”, Улаанбаатар хот. 2012 он.

Цагдаагийн байгууллага	2.70	3.19	0.49
Төрийн байгууллагуудын дундаж	2.77	3.38	0.61

Энэ үнэлгээ нь 1-ээс 5 хүртэлх үзүүлэлтээр (1-ийг туйлын шударга бус, 5-ыг маш шударга гэж ойлгож болно) гардаг учир төрийн байгууллага бүхэлдээ хэр шударга, ил тод, хариуцлагатай байгааг харж болно.

Төрийн үйлчилгээний сонгогдсон салбаруудын төрийн байгууллагын шударга байдлын түвшний үнэлгээ 3.19–3.83 хооронд үнэлэгджээ. Сонгогдсон бүх салбаруудын хувьд дээрх үзүүлэлт 2010 оныхоос 0.49-0.94 пунктээр өссөн байна. Энэ нь сүүлийн хоёр жилд төрийн байгууллагын шударга байдлын түвшин нэмэгдэж байгааг илэрхийлэх үзүүлэлт юм. Гэвч төрийн байгууллагын шударга байдлын түвшин нь салбар бүрийн хувьд харилцан адилгүй байгааг анхаарах шаардлагтай байна. Тухайлбал, шударга байдлын түвшний үнэлгээгээр хамгийн өндөр өсөлттэй буюу Гаалийн байгууллага (0.94), Нийгмийн даатгалын байгууллага (0.70) байгаа бол хамгийн бага өсөлттэй нь Цагдаагийн байгууллага (0.49), Газрын алба, Мэргэжлийн хяналтын байгууллага (0.52) байна.

Судалгааны мэдээллээс дараах дүгнэлтийг хийж байна.

- Судалгаанд оролцогчдын 24.0 хувь нь төрийн байгууллагаар үйлчлүүлэхэд хүндрэл бэрхшээл тохиолддоггүй гэж хариулсан нь 2010 оны судалгааны үр дүнтэй харьцуулбал 13.9 пунктээр нэмэгдсэн байна. Төрийн байгууллагаар үйлчлүүлж буй дөрвөн хүн тутмын гурав нь нь ямар нэгэн хүндрэл бэрхшээлтэй тулгардаг байна. Төрийн байгууллагаар үйлчлүүлэхэд төрийн албан хаагчид хүнд суртал ихтэй; төрийн үйлчилгээ авахад бүрдүүлэх бичиг баримт, шат дамжлага хэт олон, төрийн албан хаагчдын харилцааны соёл тааруу; хаана, хэнд хандаж, ямар материал бүрдүүлэх нь тодорхой бус зэрэг хүндрэл бэрхшээлүүд иргэд үйлчлүүлэгчдэд голчлон тохиолддог байна. Үүнийг өмнөх судалгааны үр дүнтэй харьцуулбал төрийн байгууллагаар үйлчлүүлэхэд учирч буй хүндрэл бэрхшээлээс төрийн албан хаагчдын хүнд суртал -9.8 пунктээр, төрийн албан хаагчдын харилцааны соёл тааруу байх явдал -5.0 пунктээр буурч, харин хаана, хэнд хандаж, ямар материал бүрдүүлэх нь тодорхой бус, төрийн албан хаагчдын мэдлэг ур, чадвар тааруу байх явдал 0.5-1.5 пунктээр нэмэгдсэн гэж судалгаанд оролцогчид хариулжээ. Нөгөө талаар хэдийгээр ерөнхийдөө төрийн байгууллагын шударга байдлын түвшний үнэлгээ дээшилсэн хэдий ч эрүүл мэнд, цагдаагийн байгууллага, газрын албаны үнэлгээ бусад судалгаанд хамрагдсан салбартай харьцуулахад харьцангуй доогуур хэвээр байна.
- Сонгосон төрийн үйлчилгээний салбаруудын дунджаар төрийн байгууллагын шударга байдлын түвшний үнэлгээ 3.38 буюу дунджаас дээгүүр гарсан хэдий ч иргэдийн хүлээлтээс 0.80 пунктээр доогуур гарсан байна.
- Үзүүлэлтийн түвшинд хариуцлагатай байдлын үзүүлэлтийн ач холбогдлын үнэлгээ 4.25, ил тод байдлын үзүүлэлтийн ач холбогдлын үнэлгээ 4.11 гэсэн дүнтэй байна. Өөрөөр хэлбэл, төрийн байгууллага шударгаар ажиллахад


хариуцлагатай байх нь ил тод байхаас илүү ач холбогдолтой гэж иргэд үзэж байна.

- Төрийн байгууллагын шударга байдлын түвшний үнэлгээ аль ч үзүүлэлтийнхээ хувьд иргэдийн хүлээлтээс доогуур байгаа бөгөөд ялангуяа, төрийн байгууллагын үйл ажиллагааны ил тод байдал дээр ихээхэн зөрүүтэй байгаад анхаарал хандуулах шаардлагатай байна. Төрийн байгууллагын шударга байдлын түвшинг үнэлж буй дэд үзүүлэлтүүдээс төрийн байгууллагын төсөв, санхүүтэй холбоотой тайлан мэдээллийг нээлттэй болгох асуудал өнгөрсөн 2 жилийн хугацаанд төдийлөн ахиц гараагүй, учир дутагдалтай байгааг иргэд үйлчлүүлэгчид өөрсдийн үнэлгээгээр харууллаа.
- “Төрийн байгууллага иргэд, үйлчлүүлэгчдийн өмнө хийж гүйцэтгэсэн ажлаа тайлагнаж хариуцлагатайгаар үйл ажиллагаа явуулахад салбарын үйл ажиллагааны үр дүнг илэрхийлэх статистик мэдээлэл, тухайлбал, үйлчлүүлэгчдийн тооны талаарх мэдээлэл хангалтгүй байна. Төрийн байгууллагын үйл ажиллагааны талаарх статистик мэдээлэл салбар, байгууллага бүр дээр харилцан адилгүй, хангалтгүй байна. Монгол Улсын ДНБ-ий хагасыг зарцуулдаг, нийт ажиллагчдын 15 орчим хувь нь ажиллаж байгаа төрийн байгууллагын салбарын үйл ажиллагааны талаарх мэдээлэл нь зөвхөн төсвийн зарцуулалт, ажиллагчдын тоогоор хязгаарлагдаж байгаад дүгнэлт хийх хэрэгтэй байна.” гэж өмнөх судалгааны тайланд дурьдаж байсан атал 2 жил өнгөрөхөд харамсалтай нь байдал өөрчлөгдөөгүй байна.
- Нийт төрийн байгууллагын дунджаар төрийн байгууллагын шударга байдлын түвшний үнэлгээ 3.38 буюу дунджаас дээгүүр түвшинд гарсан байна. Үүний дотор хариуцлагатай байдлын үзүүлэлт 3.54, ил тод байдлын үзүүлэлт 3.23 гэж үнэлэгдсэн байна. Төрийн байгууллагын шударга байдлын ерөнхий үнэлгээ иргэдийн хүлээлтээс 0.8 пунктээр, үүний дотор хариуцлагатай байдлын үзүүлэлтийн үнэлгээ 0.71 пунктээр, ил тод байдлын үзүүлэлтийн үнэлгээ 0.88 пунктээр доогуур байна. Төрийн байгууллагын шударга байдлын түвшний үнэлгээ аль ч үзүүлэлтийнхээ хувьд иргэдийн хүлээлтээс доогуур байгаад анхаарал хандуулах шаардлагатай байна.
- Эдгээрийг 2010 оны судалгааны үр дүнтэй харьцуулахад төрийн байгууллагын үйл ажиллагааны төсөв, санхүүтэй холбоотой тайлан мэдээллийн нээлттэй байдал харьцангуй доогуур хэвээр гарсан нь өнгөрсөн хоёр жилийн хугацаанд төрийн байгууллагын үйл ажиллагааны төсөв, санхүүтэй холбоотой мэдээллийн нээлттэй байдал дээшлээгүй гэсэн дүгнэлт хийж болохоор байна.

Улс төр, хууль хяналтын байгууллагын хүрээн дэх авлигын төсөөлөл: Монгол Улсын Их Хурлын 2008 оны 13 дугаар тогтоолд Монгол Улсын Мянганы хөгжлийн 9 дэх зорилгын “Авлигыг үл тэвчих уур амьсгалыг нийгмийн бүх хүрээнд хэвшүүлэх” 24 дүгээр зорилтын шалгуур үзүүлэлт “Улс төр, хууль хяналтын байгууллагын хүрээн дэх авлигын талаархи төсөөлөл”-ийн үзүүлэлтийг Авлигатай

тэмцэх газар 5 дахь удаагаа тооцон гаргасан. АТГ-аас энэхүү судалгааг 2008 оноос эхлэн жил бүр гаргаад байна. Төсөөллийн 1 гэсэн үнэлгээ авлига байхгүй, 5 гэсэн үнэлгээ авлига маш их дэлгэрснийг илэрхийлнэ. Улс төр, хууль хяналтын хүрээнд дэх авлигын төсөөллийн үнэлгээ 2012 онд 3.93 болж, 2011 оныхоос 2011 оны судалгааны үр дүнтэй харьцуулахад -0.14 пунктээр буурсан байна (Зураг 9). Өөрөөр хэлбэл, шинжээчдийн үзэж байгаагаар улс төр, хууль хяналтын хүрээнд дэх авлигын түвшин өмнөх оноос 0.14 пунктээр буурсан байна.

Зураг 9. Улс төр, хууль хяналтын байгууллагын хүрээнд дэх авлигын талаарх шинжээчдийн төсөөллийн үзүүлэлт



Улс төрийн хүрээний авлигын талаарх шинжээчдийн төсөөлөлтийн үнэлгээ 2012 онд 4.16 болж өнгөрсөн жилийн судалгааны үр дүнтэй харьцуулбал авлигад өртөх эрсдэл улс төрийн хүрээнд 0.02 пунктээр нэмэгдсэн байна. Хууль хяналтын байгууллагын авлигын төсөөлөлтийн үнэлгээ 2012 онд 3.58 болж 2011 оны судалгааны үр дүнтэй харьцуулбал 0.37 пунктээр хууль хяналтын байгууллагын авлигад өртөх эрсдэл буурсан байна (Зураг 10).

Зураг 10. Улс төр, хууль хяналтын байгууллагын хүрээн дэх авлигын талаарх шинжээчдийн төсөөллийн үзүүлэлт



Улс төр, хууль хяналтын хүрээн дэх авлигын төсөөллийн үнэлгээ ийнхүү буурахад дараахь хүчин зүйлс нөлөөлсөн байна. Үүнд:

Улс төрийн хүрээн дэх авлигад нам доторх болон төрийн албан дахь улс төрийн томилгоо (4.69), улс төрийн хүрээн дэх бизнесийн бүлэглэлүүдийн ашиг сонирхлын зөрчил (үнэлгээ 4.69), намын санхүүжилтийн механизм (4.58), сонгуулийн санхүүжилтийн механизм (4.23), УИХ-ын хууль санаачлах, тогтоох, хэрэгжилтэнд нь хяналт тавих үйл ажиллагаан дахь ашиг сонирхлын зөрчил (4.08) зэрэг хүчин зүйлс хүчтэй нөлөөлж байна (Хүснэгт 6).

Хүснэгт 6. Улс төрийн хүрээн дэх авлигыг нөхцөлдүүлэгч хүчин зүйлсийн үнэлгээ

Хүчин зүйлс	2008	2009	2010	2011	2012	Өөрчлөлт (2012-2011)
Улс төрийн томилгоо (нам дотор болон төрийн албанд)	4.71	4.80	4.42	4.46	4.69	0.23
Улс төрийн хүрээн дэх бизнес бүлэглэлүүдийн ашиг сонирхлын зөрчил	-	-	4.75	4.69	4.69	0.00
Намын санхүүжилтийн механизм	4.57	4.40	4.25	4.38	4.58	0.20
Сонгуулийн санхүүжилтийн механизм	4.50	4.20	4.42	4.50	4.23	-0.27
УИХ-ын хууль санаачлах, тогтоох, хэрэгжилтэнд нь хяналт тавих үйл	3.79	4.30	3.83	4.33	4.08	-0.25

ажиллагаан дахь ашиг сонирхлын зөрчил						
ИТХ-ын шийдвэр гаргах үйл ажиллагаан дахь ашиг сонирхлын зөрчил	3.79	3.90	3.50	4.00	3.83	-0.17
Одоогийн сонгуулийн тогтолцоо	4.14	4.10	3.83	3.45	3.64	0.18
Дундаж	4.25	4.28	4.14	4.26	4.25	-0.01

Шүүх эрх мэдлийн болон хууль сахиулах байгууллагын албан хаагчийн ёс зүй, хариуцлага тооцох механизмийн дутагдалтай (хүчин зүйлийн нөлөөллийн үнэлгээ 4.09), хууль сахиулах байгууллагын шийдвэр гаргах үйл ажиллагаан дахь ашиг сонирхлын зөрчил (3.55), хууль хяналтын байгууллагын албан хаагчийн цалин хангамж, ажиллах нөхцлийн хангалтгүй байдал (3.45) зэрэг хүчин зүйлс эдгээр байгууллагын хүрээнд авлига үүсгэх нөлөөлөл харьцангуй өндөр байна (Хүснэгт 7).

Хүснэгт 7. Шүүх, хуулийн байгууллагын хүрээнд дэх авлига үүсэхэд нөлөөлж буй хүчин зүйлсийн нөлөөллийн үнэлгээ

Хүчин зүйлс / нөлөөлөл	2008	2009	2010	2011	2012	Өсөлт, бууралт (2012-2011)
Хууль хяналтын байгууллагын шийдвэр гаргах үйл ажиллагаан дахь ашиг сонирхлын зөрчил	-	3.64	3.75	3.92	3.55	-0.37
Хууль хяналтын байгууллагын шийдвэр гаргах ажиллагааны журмын иж бүрэн хуульчлагдаагүй байдал	-	3.42	3.64	4.00	2.91	-1.09
Хууль хяналтын байгууллагын үйл ажиллагааны давхардал, чирэгдэл, үр өгөөжгүй, хяналтгүй байдал	-	3.67	4.00	4.40	3.45	-0.95
Хууль хяналтын байгууллагын албан хаагчийн цалин хангамж, ажиллах нөхцөл хангалтгүй	3.64	4	4.00	4.27	3.30	-0.97
Хууль хяналтын байгууллагын албан хаагчийн ёс зүй, хариуцлага тооцох механизм дутагдалтай	4.2	3.73	4.00	4.33	4.09	-0.24
Дундаж үнэлгээ	3.92	3.69	3.88	4.18	3.46	-0.72

Судалгаанд дараахь дүгнэлтийг өгч байна.

- 2012 онд улс төр, хууль хяналтын хүрээн дэх авлигын талаарх төсөөллийн үнэлгээ 3.93 болж, 2010, 2011 оны түвшингээс 0.14 пунктээр буурч, 2009 оны түвшинтэй адил болсон байна.
- Улс төрийн хүрээн дэх авлигын талаарх төсөөллийн үнэлгээ болон хуулийн байгууллагын хүрээн дэх авлигын төсөөллийн үнэлгээний хоорондын харьцаа нь 2009 онд 54 : 46, 2010 онд 51 : 49, 2011 онд 51 : 49, 2012 онд 54 : 46 болсноос үзвэл улс төрийн хүрээн дэх авлигын байдал хуулийн байгууллагын хүрээн дэх авлигаас илүү ноцтой байна гэж дүгнэхээр байна.
- Засгийн газар, яамдын болон цагдаагийн байгууллагын авлигад өртөмтгий байдал судалгааны явцад харьцангуй өндөр түвшинд байгаад анхаарал хандуулах шаардлагатай байна. Түүнчлэн эдгээр байгууллага дотроо удирдлагын түвшинд, өөрөөр хэлбэр сайд, дэд сайд, төрийн нарийн бичгийн дарга нарын түвшинд болон замын цагдаагийн албаны авлигад өртөх эрсдэл өндөр байна.
- Авлигад нөлөөлөх хүчин зүйлсээс нам доторх болон төрийн албан дахь улс төрийн томилгоо, улс төрийн хүрээн дэх бизнесийн бүлэглэлүүдийн ашиг сонирхлын зөрчил, намын санхүүжилтийн болон сонгуулийн санхүүжилтийн механизм, хуулийн байгууллагын ёс зүйгүй байдал, хариуцлага тооцох сул тогтолцоо, ашиг сонирхлын зөрчил зэрэг байдал өндөр үзүүлэлттэй гарч байна. Иймээс улс төр, хуулийн байгууллагын хүрээний ашиг сонирхлын зөрчлийг таслан зогсоох, үүний тулд Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн хэрэгжилтийг эрчимжүүлэх шаардлагатай.
- Улс төрчид болон хуулийн байгууллагын албан тушаалтнууд өөртөө болон бусдад давуу байдал бий болгох шийдвэр гаргуулахын тулд шууд буюу шууд бус байдлаар албан тушаалтны зөрчлийг илрүүлж түүгээр нь дарамтлах, мөнгө, бэлэг өгөх, ашиг орлого хуваахаар амлах, гадаад арга хэмжээний зардал даах, дарамт шахалт үзүүлэх зэрэг арга хэлбэрүүдийг хэрэглэх нь түгээмэл байдаг байна. Иймээс албан тушаалтанд хариуцлага тооцох механизмыг өнөөгийн түвшнээс илүү ил тод, шударга байхаар зохицуулах, албан тушаалтны хөрөнгө, орлого, бэлэг, гадаадад зорчихтой холбоотой үйл ажиллагаанд тавих хяналтыг чангатгах талаар анхаарах шаардлагатай.
- Албан тушаалтнууд авлигаар олж авсан хөрөнгийг юуны өмнө амьдралын наад захын хэрэгцээгээ хангахад зарцуулдаг болох нь судалгаагаар тогтоогдож байна. Энэхүү хэрэгцээнээс илүү гарсныг хадгаламж, хувьцаа болгодог байна. Үүнээс үзвэл албан тушаалтныг авлигад өртөхөөс урьдчилан сэргийлэхийн тулд тэдний хууль ёсоор олох орлогын хэмжээг нэмэгдүүлэх шаардлагатай.

САНАЛ, ДҮГНЭЛТ

Авлигатай тэмцэх газар нь 2012 онд авлигын эсрэг соён гэгээрүүлэх үйл ажиллагааг эрчимжүүлэхэд иргэний нийгмийн байгууллага болон олон нийтийг татан оролцуулах, өсвөр үе, залуучуудад шударга ёсны үзлийг зөв төлөвшүүлэх, албан тушаалтны хөрөнгө, орлогын мэдүүлгийн бүрдүүлэлт, хяналт, шалгалтыг хууль тогтоомжийн шаардлагад бүрэн нийцүүлэн сайжруулах, үр дүнд хүргэх, байгууллага, албан хаагчийн аюулгүй байдал, дотоодын хяналт шалгалтын үйл ажиллагааг төгөлдөржүүлэх, олон улсын туршлагад тулгуурлан судалгаа шинжилгээний ажлын аргачлалыг улам боловсронгуй болгох, хууль дээдлэх зарчмыг эрхэмлэж, авлигын гэмт хэргийн илрүүлэлт, мөрдөн байцаалтын үр дүнг нэмэгдүүлэх зорилт дэвшүүлэн, хуулиар хүлээсэн үндсэн чиг үүрэг, зорилго, зорилтоо хэрэгжүүлэхэд хэлтэс, албадын хамтын ажиллагааг нэгтгэн зохион байгуулж, албан хаагчид, ажилтнуудын ажлын үр дүнг дээшлүүлэхэд үйл ажиллагаагаа чиглүүлэн ажиллалаа. Авлигатай тэмцэх газрын 2012 онд хийж гүйцэтгэсэн ажлаас харахад тус газар Авлигын эсрэг хуулиар хүлээсэн үндсэн чиг үүргээ зохих ёсоор гүйцэтгэсэн байна гэж дүгнэх боломжтой байна.

Авлигатай тэмцэх эрх зүйн орчинг боловсронгуй болгох, НҮБ-ын Авлигын эсрэг конвенцийн үзэл баримтлалд үндэсний хууль тогтоомжийг нийцүүлэх чиглэлээр бодитой ахиц дэвшил гарч, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлын зөрчлийг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль батлагдан, Авлигын эсрэг хууль болон Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт орж, Албан тушаалтны хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлгийн маягт шинэчлэгдэн, Засгийн газрын 2 тогтоол хэрэгжиж эхэлсэн болно.

Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль батлагдсантай холбогдуулан хууль тогтоомжийг хэрэгжүүлэх, авилгын гэмт хэргийг илрүүлэх, мөрдөн шалгах, урьдчилан сэргийлэх, хянан шалгах, судалгаа, дүн шинжилгээ явуулах оновчтой бүтэц, орон тоо, санхүүжилтын асуудлыг УИХ-аар шийдвэрлүүллээ. Улсын Их Хурлын 2012 оны 55 дугаар тогтоолоор Авлигатай тэмцэх газрын зохион байгуулалтын бүтэц, орон тоог шинэчлэн баталж, орон тооны дээд хязгаарыг 145 байхаар тогтоосны зэрэгцээ байгууллагын өргөтгөлийн барилгыг ашиглалтад оруулсан нь Авлигатай тэмцэх газрыг чадавхжуулах, бэхжүүлэхэд том хувь нэмэр, хөрөнгө оруулалт боллоо гэж үзэж байна.

Мөн Бүгд Найрамдах Австри Улсын Вена хотод 2010 оны 9 дүгээр сарын 02-ны өдөр байгуулсан “Авлигын эсрэг олон улсын академийг олон улсын байгууллага болгон үүсгэн байгуулах тухай хэлэлцээр”-т Монгол Улсын Засгийн газрын өргөн мэдүүлснээр нэгдэн орох тухай Монгол Улсын хуулийг Улсын Их Хурлаас 2012 оны 12 дугаар сарын 05-ны өдөр баталсан нь тус байгууллагын ажилтан, албан хаагчдыг олон улсын түвшинд сургах, хүний нөөцийн чадвар, чадамжийг бэхжүүлэх чиглэлээр төр, засгаас онцгой анхаарч байгааг онцлон тэмдэглэх нь зүйтэй юм.

2012 оны үйл ажиллагаа өмнөх оны мөн үетэй харьцуулахад идэвхжсэн байгаа нь орон тоо нэмэгдэж ажилтан албан хаагчид ажлын байрны давхардал багасч тус тусын ажлын байрны тодорхойлолтод заагдсан ажлыг хэрэгжүүлэх боломжтой болсонтой тодорхой хэмжээгээр холбоотой гэж үзэж байна.

Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлын зөрчлийг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль шинээр батлагдан гарч, Авлигын эсрэг хуульд нэмэлт, өөрчлөлт орж, Албан тушаалтны хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлгийн маягт шинэчлэгдэн батлагдсан нь байгууллагын үйл ажиллагаанд зохих нөлөө үзүүлснээс гадна ажлын ачаалал нэмэгдэх гол үндэс болсон.

Нийтийн албанд томилогдохоор нэр дэвшсэн этгээдийн урьдчилсан мэдүүлгийг хянадаг болсноор иргэд олон нийтийн дунд танил талаа харж томилгоо хийдэг, томилогдсон төрийн албан хаагчид хүнд сурталтай, хувийн эрх ашгийн үүднээс аливаа асуудалд ханддаг, авлига, хээл хахууль авдаг гэсэн сөрөг ойлголтыг бууруулахад эерэг нөлөө үзүүлж байна. Гэвч урьдчилсан мэдүүлгийг хянуулахгүйгээр нийтийн албанд томилж байгаа, томилсоны дараа хянуулахаар тус газарт ирүүлдэг, мэдүүлгийг батлагдсан маягтын дагуу биш өөр маягтаар хүлээн авдаг, мэдүүлэгт заасан холбогдох материалыг дутуу ирүүлж байгаа нь ажилтнуудын ажлын ачааллыг нэмэгдүүлэн, цаг хугацаа алдах зэрэг сөрөг нөхцөлийг бүрдүүлж байна. Цаашид албан тушаалд томилгоо хийгдсэний дараа урьдчилсан мэдүүлгийг хянуулахаар ирүүлж байгаа зөрчилд хариуцлага тооцуулах тухай асуудлыг хуульд тусгаж оруулах, “Нийтийн албанд томилогдохоор нэр дэвшсэн этгээд” гэдэгт шилжин томилогдсон, албан тушаал нь өөрчлөгдсөн, сэлгэн ажиллуулсан, шүүхийн шийдвэрийн дагуу ажилд эргүүлэн томилогдсон, түр хугацаагаар томилогдсон албан тушаалтнуудыг хэрхэн хамруулах талаар хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах санал боловсруулах ажлуудыг нэн түрүүнд хийж гүйцэтгэх шаардлагатай байна.

Тус газраас “Хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлгийн мэдээллийн систем”-ийг хийж гүйцэтгэн 2013 оны бүрдүүлэлтийн үйл ажиллагаанд ашиглах тул энэхүү цогц програм өргөдөл, гомдол, ХАСХОМ, урьдчилсан мэдүүлгийн бүртгэл, Эрх бүхий албан тушаалтны бүртгэл зэрэг програм хангамжууд хийгдэх бөгөөд хяналт шалгалтын үйл ажиллагааг түргэн шуурхай, үр дүнтэй, судалгаа, дүн шинжилгээг хийх боломжтой болох юм.

2012 онд явуулсан сургалт, сурталчилгааны дийлэнх хувийг Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, Авлигын эсрэг хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль, мэдүүлэг, мэдэгдлийн маягтыг бөглөх аргачлалын талаарх сургалт эзэлж байна. Авлигын гэмт хэрэг, зөрчил, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх төрийн байгууллага, албан тушаалтанд чиглэсэн зорилтот сургалт, сурталчилгааны ажлыг тодорхой жишээ баримтад тулгуурлан явуулахад анхаарч шүүгч, хууль тогтоогчид, эрдэмтэн судлаачид, мэргэжлийн байгууллагын ажилтнуудтай хамтран сурах бичиг, гарын авлага боловсруулан хууль тогтоомж

сурталчлах, сургалт зохион байгуулах үйл ажиллагаанд ашиглах ажлыг яаралтай эхлүүлэх нь энэ чиглэлд анхаарах тулгамдсан асуудал юм.

Иргэдээс тус газарт гаргаж байгаа өргөдөл, гомдлын 35 хувь нь албан тушаалтан хууль тогтоомж зөрчсөн тухай, 30,8 хувь нь албан тушаалтны мэдүүлгийг хянуулах, 22,8 хувь нь албан тушаалаа урвуулан ашигласан байж болзошгүй гэж үзсэн агуулгатай байхад харин мөрдөн байцаалт явуулсан хэргийн албан тушаалын байдлаа урвуулах 22,6 хувь, албан тушаалаа хэтрүүлэх 10,9 хувь, хээл хахууль авах 13,2 хувийг буюу дийлэнх хувийг эзэлж байгаа нь өргөдөл, гомдлыг шалгах, гэмт хэргийг илрүүлэх үүрэг бүхий мөрдөн байцаагч, хяналт шалгалтын ажилтнуудыг эдийн засаг, санхүүгийн болон бусад чиглэлийн цогц мэдлэг олгон чадавхжуулах, хууль, хяналт шалгалтын байгууллагуудтай хамтын ажиллагааг сайжруулах шаардлагатай байгааг илтгэж байна.

Авлигын эсрэг хууль батлагдаж, Авлигатай тэмцэх газар байгуулагдан үйл ажиллагаа явуулж эхэлснээс хойш 6 жилийн хугацаа өнгөрч байна. Улсын хэмжээнд авлигатай тэмцэх үйл ажиллагааг зохион байгуулах, уялдуулан зохицуулах, бусад байгууллагын авлигатай тэмцэх үйл ажиллагааг идэвхжүүлэх, хариуцлагын механизмыг зөв бүрдүүлэхийн тулд Авлигын эсрэг хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах зайлгүй шаардлага тулгарч байна. Иймд хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах санал боловсруулж эрх бүхий байгууллагад хүргүүлэхээр холбогдох ажлыг эхлүүлээд байна. Тухайлбал, Авлигатай тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үйл ажиллагааг үр дүнтэй, тогтмол, тасралтгүй явуулахад хүндрэлтэй, хүн хүч, хөрөнгө, санхүүгийн боломжоос шалтгаалан аймаг, сумдад хүрч ажиллахад бэрхшээлтэй байна. Хөдөө орон нутагт авлигын эсрэг үйл ажиллагааг явуулах тодорхой бодлого, төлөвлөгөөтэй ажиллах, ялангуяа орон нутгийн төрийн болон нутгийн захиргааны байгууллагуудын авлигатай тэмцэх үйл ажиллагааг идэвхжүүлэхэд анхаарч ажиллах шаардлагатай байна. Авлигатай тэмцэх газар нь орон нутагт салбар, бүтцийн нэгжгүй байгууллага. Иймд Авлигатай тэмцэх газрын салбарыг орон нутагт байгуулах нь Авлигын эсрэг хууль болон Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль тогтоомжийг хэрэгжүүлэх, соён гэгээрүүлэх ажлыг зохион байгуулах, мөрдөн байцаалтын ажиллагаанд саад учруулах байдлыг таслан зогсоох, албан хаагчдын аюулгүй байдлыг хангах, мэдээ мэдээлэл түргэн шуурхай олж авах ажлыг үр дүнтэй болгоход чухал ач холбогдолтой зохицуулалт болох юм.

Авлигын эсрэг хуульд заасны дагуу төрийн үйлчилгээг хүнд суртал, чирэгдэлгүй үзүүлэх, мэдээллийг нээлттэй болгох, үйл ажиллагаагаа нээлттэй байлгах, төрийн албан хаагчид ёс зүйн дүрмээ сахин биелүүлэх зэрэг чиглэлээр төрийн болон бусад байгууллагуудад хандан зөвлөмж өгч ажилладаг. Мөн уг хуульд иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын авлигаас урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх талаар хүлээх үүргийг тусгайлан заасан байдаг. Гэвч энэхүү үүргээ биелүүлэх талаар аж ахуйн нэгж, байгууллагууд идэвх санаачилга гаргадаггүй,

үүргээ биелүүлдэггүй, АТГ-ын зөвлөмжийг хэрэгжүүлдэггүй, хэрэгжилтэд нь ач холбогдол өгдөггүй зэрэг дутагдал гарч байна. Иймд Авлигатай тэмцэх газар дээрх чиглэлээр зөвхөн зөвлөмж өгөөд зогсохгүй, зөвлөмжийн хэрэгжилтэд хяналт тавих, шаардлага хүргүүлэх, авлигаас урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх, хувийн ашиг сонирхлын болон хөрөнгө, орлого, мэдүүлгийн чиглэлээр Авлигын эсрэг хуульд заасан үүргээ биелүүлээгүй тохиолдолд захиргааны хариуцлага хүлээлгэх талаар эрх зүйн зохицуулалт хийх шаардлагатай байна.

Авлигын эсрэг хууль тогтоомжийг зөрчсөн этгээдэд зөвхөн шүүгч захиргааны хариуцлага хүлээлгэдэг. Иймд энэ заалтыг хариуцлага ногдуулах эрх бүхий субъект нь Авлигатай тэмцэх газрын эрх бүхий албан тушаалтан байхаар өөрчлөх нь Авлигын эсрэг хууль тогтоомжийг үр дүнтэй хэрэгжүүлэх, зөрчил бүрт цаг алдалгүй хариуцлага тооцоход ач холбогдолтой гэж үзэж байна.

Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын төлөөлөгч хөрөнгө орлогоо мэдүүлээгүй, мэдүүлгийг санаатай худал мэдүүлсэн бол энэ нь түүнийг албан тушаалаас нь огцруулах үндэслэл болох талаар Авлигын эсрэг хуульд тусгаж өгөх шаардлагатай байгаагийн зэрэгцээ Авлигын эсрэг хуулийн үйлчлэлд хамаарах этгээдийг Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн үйлчлэлд хамаарах этгээдтэй нийцүүлэх зорилгоор хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах нь зүйтэй гэж үзэж байна.

Авлигатай тэмцэх газраас өөрийн харьяаллын гомдол, мэдээлэл, эрүүгийн хэргийг шалгах явцад албан тушаалтны хууль зөрчсөн, албаны эрх мэдэл, албан тушаалын байдлаа урвуулсан, албаны эрх мэдлээ хэтрүүлсэн, төсвийн хөрөнгийг зориулалтын бусаар зарцуулсан үйлдэл тогтоогддог. Гэвч Эрүүгийн хуульд заасан албан тушаалын гэмт хэргийн бүрэлдэхүүний объектив талын шинж болох хохирлын хэмжээ үлэмж хэмжээний хохирол /7.020,0001 төгрөг/-т хүрээгүйн улмаас албан тушаалын гэмт хэргийн бүрэлдэхүүнгүй болж тухайн гомдол мэдээлэл, эрүүгийн хэргийг Мөрдөн шалгах хэлтсээс харьяалах хуулийн байгууллагад хандан Эрүүгийн хуульд заасан өөр гэмт хэргийн бүрэлдэхүүний шинжтэй эсэхийг шалгуулахаар шилжүүлдэг боловч хүлээн авсан байгууллагууд гомдол, мэдээлэл, эрүүгийн хэргийг шалгаж хэрхэн шийдвэрлэсэн талаар эргэж хариу мэдэгддэггүй, төрийн байгууллага хоорондын ажлын уялдаа, зохицуулалт муугаас тухайн гомдол, мэдээлэл, эрүүгийн хэргийн хувь заяа бүдгэрэхэд хүрч байна.

Хэдийгээр тухайн гомдол, мэдээлэл, эрүүгийн хэрэг албан тушаалын гэмт хэргийн бүрэлдэхүүнгүй үндэслэлээр холбогдох хуулийн байгууллагад шилжин очиж байгаа ч зөрчлийг арилгах, зөрчигдсэн нийгмийн харилцааг сэргээн тогтоох, албан тушаалтны буруутай үйлдлийн улмаас учруулсан бага бус хэмжээний хохирлыг хохирсон иргэн, хуулийн этгээдэд нөхөн төлүүлж тэднийг хохиролгүй болгох, буруутай албан тушаалтанд хуульд заасан бусад хариуцлага хүлээлгэх, хууль зөрчсөн үйлдлийн шалтгаан нөхцлийг шалган тогтоож улмаар гэмт хэргээс

урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг зохион байгуулах үүрэгтэй. Өнөөдөр энэ ажил зохих түвшинд хийгдэхгүй байгаад анхаарал хандуулах шаардлагатай байна.

Эрүүгийн байцаан шийтгэх хуульд зааснаар хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч гэмт хэргийн шинжтэй гомдол, мэдээлэл, эрүүгийн хэрэг гэмт хэргийн бүрэлдэхүүнгүй болох нь тогтоогдвол гомдол мэдээллийг эрүүгийн хэрэг үүсгэхээс татгалзах, эрүүгийн хэргийг хэрэгсэхгүй болгох саналтайгаар прокурорт хүргүүлж шийдвэрлүүлэхээр тусгасан. Харин эрүүгийн хэрэг үүсгэхээс татгалзах, эрүүгийн хэргийг хэрэгсэхгүй болгох саналтайгаар прокурорт хүргүүлж шийдвэрлүүлж байгаа хэрэг, гомдол, мэдээлэлд хэрэг бүртгэгч мөрдөн байцаагч нар албан тушаалтны үйлдсэн зөрчлийг засуулах, зөрчигдсөн нийгмийн харилцааг сэргээн тогтоох, албан тушаалтны буруутай үйлдлийн улмаас учруулсан бага бус хэмжээний хохирлыг хохирсон иргэн, хуулийн этгээдэд нөхөн төлүүлж тэднийг хохиролгүй болгох, эдгээр үүргээ биелүүлээгүй албан тушаалтанд хүлээлгэх хариуцлагыг тусгасан эрх зүйн зохицуулалт байхгүй байна.

Харин Прокурорын байгууллагын тухай хуулийн 11 дүгээр зүйлд захиргааны хэрэг бүртгэлийн үйл ажиллагаанд хяналт тавих прокурорын үйл ажиллагааг хуульчилсан бөгөөд тэрээр албан тушаалтны захиргааны шинжтэй зөрчлийг хянан шалгах ажиллагаанд хяналт тавьж ажилладаг. Тухайлбал, мөн хуулийн 16 дугаар зүйлийн 16.1-д прокурор төрийн ашиг сонирхол зөрчигдсөн гэж үзвэл төрийн байгууллагын хүсэлтээр иргэний хэргийг хянан шийдвэрлэх ажиллагаанд зохигчийн төлөөлөгчөөр оролцох үүргийнхээ дагуу дээр дурдсан хууль зөрчсөн зөрчлийг засуулах, зөрчигдсөн нийгмийн харилцааг сэргээн тогтоох, албан тушаалтны буруутай үйлдлийн улмаас учруулсан бага бус хэмжээний хохирлыг хохирсон иргэн, хуулийн этгээдэд нөхөн төлүүлж тэднийг хохиролгүй болгох ажлыг гүйцэтгэхээр хуульчилжээ. Түүнчлэн мөн хуулийн 16 дугаар зүйлийн 16.5-д Прокурор иргэний хэрэгт итгэмжлэлгүйгээр хэрэг маргаанд оролцохоор заасан байна.

Иймд нэгэнт төрийн байгууллагаас хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтаар шалгаж тогтоосон хэрэгсэхгүй болгосон эрүүгийн хэрэг, эрүүгийн хэрэг үүсгэхээс татгалзаж шийдвэрлэсэн гомдол, мэдээлэлд авагдсан баримтад тулгуурлан прокурор дээр дурдсан ажиллагааг гүйцэтгэх боломжтой байх тул хуулийн энэ заалтыг практик дээр хэрэгжүүлэх зайлшгүй шаардлага байна.

Мөн төрийн байгууллага хоорондын харилцаа хамтын ажиллагаа, уялдаа холбоог сайжруулах, мэдээллийг түргэн хугацаанд саадгүй солилцож байх, гэмт хэргийн шинжтэй болон бусад гомдол мэдээлэл, эрүүгийн хэргийг харьяаллаар хүлээн авч шалгасан төрийн байгууллагууд тухайн асуудлын шийдвэрлэлтийг холбогдох байгууллагад хүргүүлж байх эрх зүйн зохицуулалтыг бий болгох шаардлагатай.

Улсын Их Хурлын 2007 оны 7 дугаар тогтоолын дагуу Авлигатай тэмцэх газрын албан хаагчдад тэргүүн комиссар, эрхэлсэн комиссар, ахлах комиссар, дэд комиссар гэсэн зэрэг дэвийг олгодог. Авлигатай тэмцэх газраас иргэдэд төрийн

үйлчилгээ үзүүлэхэд цолны нэршил ойлгомжгүй, олон улсын хэмжээнд хэвшин тогтсон цэргийн болон цэрэгжсэн байгууллагын албан хаагчийн цолны нийтлэг ойлголтоос гажууд, гадаад орон, олон улсын байгууллага, ижил төстэй үйл ажиллагаа явуулдаг байгууллагуудтай хамтран ажиллах, харилцахад бэрхшээлтэй, бүрэн утгаараа орчуулагддаггүй, оновчгүй байх зэрэг хүндрэл гарч байна. Иймд Авлигатай тэмцэх газрын албан хаагчдын зэрэг дэвийг дэлхий нийтийн жишиг, албаны онцлог, албан хаагчдын нийтлэг эрх ашигт нийцүүлж цэргийн цолоор солих нь зүйтэй юм.

Түүнчлэн тусгай чиг үүрэг хэрэгжүүлдэг ижил төстэй байгууллагуудтай адил цол, дүрэмт хувцасны хангамж, тэтгэвэр тэтгэмжийн талаар төсөл боловсруулан дээд шатны байгууллага, албан тушаалтанд тавьж шийдвэрлүүлэх, тухайлбал, Авлигатай тэмцэх газарт төрийн тусгай албан тушаалд томилогдон ажиллаж байгаа хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, гүйцэтгэх ажилтнууд хүнд нөхцөлд ажиллаж байдаг учраас тэдний өндөр насны тэтгэвэрт гарах насны хязгаарыг өөрчлөх буюу ажилтны тэтгэвэр, тэтгэмжийн асуудлыг Авлигын эсрэг хуульд өөрчлөн зохицуулах шаардлагатай байна.

Авлигын эсрэг хууль тогтоомжийг боловсронгуй болгох ажлын хүрээнд Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай, Галт зэвсгийн тухай, Банкны тухай болон Төрийн аудитын тухай зэрэг хуульд нэмэлт оруулах хэрэгцээ шаардлага байна. Тухайлбал, Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.6-д “зэвсэгт хүчин, цагдаа, улсын аюулгүй байдлыг хангах, шүүхийн шийдвэр биелүүлэх байгууллагын хэрэгцээнд зориулан импортоор авч байгаа зэвсэг, тусгай техник хэрэгсэл”-ийг нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөхөөр заасан байдаг. Гэвч Авлигатай тэмцэх газар байгуулагдахаас өмнө батлагдсан энэ хуулийн заалт манай байгууллагад хамаарахгүй байгаа тул албаны хэрэгцээнд зориулан импортоор оруулж ирсэн тусгай техник хэрэгсэл нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөгдөхгүй байгаа юм. Иймд Авлигатай тэмцэх газрын гүйцэтгэх ажил, хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт явуулдаг албан хаагч Авлигын эсрэг хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1.8-д заасны дагуу галт зэвсэг, бие хамгаалах тусгай хэрэгсэл, мэх хэрэглэх эрхтэй байхаар заасныг үндэслэн зэвсэгт хүчин, цагдаагийн байгууллагуудтай адилтган авч үзэж Нэмэгдсэн өртгийн албан татварын хуульд нэмэлт оруулах шаардлагатай байна.

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн дагуу тагнуулын байгууллага, зэвсэгт хүчин, цагдаагийн гүйцэтгэх албанд зориулсан төсвийн хөрөнгийн зарцуулалтад Монгол Улсын Ерөнхий аудитор болон Улсын Их Хурлаас итгэмжилсэн ажилтан аудит хийдэг. Авлигатай тэмцэх газар энэ заалтын дагуу аудит хийлгэх боломжгүй нөхцөл байдал үүсдэг тул уг заалтад Авлигатай тэмцэх газрыг нэмж оруулах нь зүйтэй.

Банкны тухай хуульд банкнаас лавлагаа, мэдээлэл авах эрх нь зөвхөн шүүх, прокурор, цагдаагийн байгууллагад олгогдсон ба тэдэнтэй ижил хууль сахиулах үүрэг бүхий Авлигатай тэмцэх газарт энэ эрх олгогдоогүй байгаа нь мөрдөн байцаалт явуулах болон хөрөнгө, орлогын мэдүүлгийг хянан шалгах

ажиллагаанд хүндрэл учруулж байна. Өөрөөр хэлбэл, Мөрдөн байцаах албаны ажилтнууд эрүүгийн хэрэгт прокуророор тогтоол батлуулж харилцагч, хадгаламж эзэмшигч нарын мэдээллийг авч байгаа бөгөөд харин Гүйцэтгэх ажлын хэлтэс, Аюулгүй байдал хяналт шалгалт, нууцын алба, Хяналт шалгалтын албаны ажилтнууд дансны мэдээллийг гаргуулан авах боломжгүй байгаа юм. Иймд харилцагч, хадгаламж эзэмшигчийн мэдээллийг прокурорын зөвшөөрөлтэйгээр бус шууд мөрдөн байцаагчийн тогтоолоор банкнаас авах шаардлагатай байгаа бөгөөд ингэснээр мөрдөн байцаалт шуурхай явагдах хэргийг нотлох чухал баримтуудыг түргэн шуурхай гаргуулж авах нөхцөл бүрдэх юм.

Түүнчлэн 1/ Авлигатай тэмцэх төрийн бодлогын баримт бичиг буюу Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр/стратеги/-ийг нэн яаралтай батлан мөрдүүлэх, 2/ НҮБ-ын Авлигын эсрэг конвенцид дотоодын хууль тогтоомжийг нийцүүлэх, конвенцийн гишүүн орны хувьд хүлээсэн үүргээ биелүүлэх, бусад улсын ижил төстэй байгууллагуудтай хамтран ажиллах талаар анхаарч, харилцаа холбоогоо өргөжүүлэн шинэ шатанд гаргах, шинээр батлагдан гарсан хууль тогтоомжийг хэрэгжүүлэхэд гадаад улс орны сайн арга туршлагыг судлах, ажилтнуудыг сургаж бэлтгэх, чадавхийг сайжруулах зорилгоор олон улсын төсөл хөтөлбөртэй үйл ажиллагаагаа идэвхжүүлэх, 3/ Авлигын эсрэг хууль болон Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль тогтоомжийн үйлчлэлд хамаарах байгууллага, албан тушаалтнуудаас гадна бизнес эрхлэгч, хувийн хэвшил, төрийн бус байгууллага, иргэнтэй хамтарч ажиллах үр дүнтэй ажлуудыг санаачлан хэрэгжүүлэх, 4/ яам, агентлаг, аймаг, нийслэлийн төрийн болон нутгийн өөрөө удирдах байгууллагууд өөрсдийн хариуцсан салбар, орон нутагтаа бодитой, үр дүн гарахуйц авлигатай тэмцэх ажлыг зохион байгуулах, 5/ орон нутаг дахь авлигын эсрэг үйл ажиллагааг бүх талаар дэмжих, сайн туршлагыг нэвтрүүлэхэд мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгөх, орон нутгийн иргэдтэй биечилсэн нүүр тулсан уулзалтыг зохион байгуулж, бодит байдалтай танилцах, тэдэнд хүрч ажиллахад анхаарах 6/ Авлигын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх ажлын хүрээнд Ерөнхий боловсролын сургуулийн сургалтын хөтөлбөрт шударга ёсны чиглэлээр хичээл оруулах талаар Боловсрол шинжлэх ухааны яамтай 2013 онд хамтран ажиллах нь авлигыг үл тэвчих үзлийг сурагчдад төлөвшүүлэх, шударга ёсыг түгээн дэлгэрүүлэхэд оруулах чухал хувь нэмэр болох болно.

АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ГАЗАР